



Тайланг бэлтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын
захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор

М.Давааням

Аудитын менежер

З.Ариунзаяа

Гүйцэтгэлийн аудитын газрын
Ахлах аудитор

Б.Долгорсүрэн

Чанарын баталгаажуулалтын
албаны
Ахлах аудитор

И.Туяа

Санхүүгийн аудитын газрын
Ахлах аудитор

Г.Жавхлан

Гүйцэтгэлийн аудитын газрын
Аудитор

М.Наранжаргал

Б.Хаш-Эрдэнэ

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт3

Дүрслэлийн товьёг3

Хүснэгтэн мэдээллийн товьёг3

Хавсралтын товьёг3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх
мэдэгдэл4

Ерөнхий мэдээлэл7

БҮЛЭГ 1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа
холбогдох хуулийг зөрчиж иржээ.....8

*Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчмыг мөрдөөгүй
байна8*

*Агуулахын үлдэгдлийг зохистой түвшинд хянаж нөөцийг
тооцохгүйгээр худалдан авалт хийж, ашиглалтгүй болон
илүүдэл хөрөнгө бий болгожээ9*

БҮЛЭГ 2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн газарт үйл
ажиллагаа явуулж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл
ажиллагаа хууль, журамд нийцэхгүй байна11

*Гүйцэтгэх удирдлага Зөвлөлийн шийдвэргүйгээр хүдэр
боловсруулах үйлдвэр байгуулсан байна11*

*ЭБМЗ-өөр хянуулаагүй, дүгнэлтгүй ТЭЗҮ-ийг ашиглан хүдэр
боловсруулах үйлдвэрийг байгуулж, үйлдвэрлэл, туршилт
судалгааны ажлыг явуулсаар байна13*

*Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах зарим гэрээ хүчин
төгөлдөр бус, холбогдох хуультай нийцүүлээгүй байна.....14*

*Газар ашиглуулах гэрээний заалтууд Газрын тухай хуулийн
зарим заалттай нийцэхгүй байна15*

Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна15

*Хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэрээнд
заасан нөхцөлийн дагуу үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй
байна16*

БҮЛЭГ 3. Бүтээгдэхүүн борлуулах гэрээний нөхцөлд тохирсон
зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх зардлыг үндэслэлгүй
тогтоож, охин болон хараат компаниудад үр ашиггүй хөрөнгө
оруулалт хийсэн байна.....19

*Бүтээгдэхүүн борлуулах гэрээний нөхцөлд тохирсон зэсийн
баяжмал хайлуулах, цэвэршүүлэх зардлыг үндэслэлгүй
тогтоосон байна.....19*

*Борлуулалтын гэрээний дагуу бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй
байна20*

*Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт үр
ашиггүй байна.....21*

*Гүйцэтгэх удирдлага 6.6 тэрбум төгрөгийг холбогдох хууль,
журмыг зөрчин үр ашиггүй зарцуулжээ.22*



лавлах, холбогдох саналаа
262451 дугаарын утсаар
харилцана уу.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр иргэн, аж ахуйн нэгжид 49.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, 1.7 тэрбум төгрөгийн хандив өгсөн байна.....22

Үйлдвэрийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж иржээ23

БҮЛЭГ 4. Дотоод хяналтын тогтолцоог боловсонгүй болгох шаардлагатай байна25

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартыг хэрэгжүүлээгүй байна25

Дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагаа үйлдвэрийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэгдээгүй байна25

Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тогтоосон 2 төлбөрийн актыг барагдуулаагүй байна25

ДҮГНЭЛТ.....28

ЗӨВЛӨМЖ.....30

Холбогдох байгууллагын санал32

Үндэсний аудитын газрын тайлбар33

Тайланг баталгаажуулсан Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал.....38

Аудитын явцад илэрсэн зөрчлийн нэгтгэл.....39

Хавсралтууд.....40

Тайланг Үндэсний аудитын газрын www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.

Хаяг:
Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МУИС	Монгол улсын их сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБМЗ	Эрдэс, баялагийн мэргэжлийн зөвлөл

Дүрслэлийн товьёг

Дүрслэл № 1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт
Дүрслэл № 2	Нийт орлого, зардал, цэвэр ашгийн судалгаа

Хүснэгтэн мэдээллийн товьёг

Хүснэгт № 1	Улс, орон нутгийн төсөвт төлсөн татварын судалгаа
Хүснэгт № 2	2015-2017 онд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын судалгаа
Хүснэгт № 3	Агуулахын үлдэгдлийн судалгаа
Хүснэгт № 4	Эргэлтийн хөрөнгийн насжилтын судалгаа
Хүснэгт № 5	Ашиглагдахгүй хөрөнгийн үлдэгдлийн судалгаа
Хүснэгт № 6	Зөвлөлийн хуралдаанаар өгсөн чиглэлийн судалгаа
Хүснэгт № 7	“Ачит Ихт” ХХК-ийн экспортод гаргасан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын орлогын дүнд суурилан тооцсон ашиглалтын төлбөрийн тооцоолол
Хүснэгт № 8	“Ачит ихт” ХХК-ийн гаалийн бүрдүүлэлтийн тоо, мэдээнд үндэслэн тооцсон борлуулалтын орлого, ашиглалтын төлбөрийн тооцоолол
Хүснэгт № 9	“Ачит Ихт” ХХК-ийн төлбөл зохих ногдол ашгийн судалгаа
Хүснэгт № 10	Борлуулсан зэс болон молибдений баяжмалын тоо хэмжээ, үнийн судалгаа
Хүснэгт № 11	Зэсийн баяжмалыг хайлуулах болон цэвэршүүлэх зардлын харьцуулсан судалгаа
Хүснэгт № 12	Борлуулалтын гэрээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа
Хүснэгт № 13	Охин болон хараат компанийн ерөнхий мэдээллийн судалгаа
Хүснэгт № 14	“Шим технолоджи” ХХК-ийн өрийн судалгаа
Хүснэгт № 15	201,501,502 тоот орон сууцны хэрэглээний зардлын тооцоо
Хүснэгт № 16	Аудитаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн судалгаа

Хавсралтын товьёг

Хавсралт № 1	Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 2015, 2016 он болон 2017 оны 3-р улиралд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны нэгтгэсэн судалгаа
Хавсралт № 2	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ашиглалтын болон эдэлбэр газруудад үйл ажиллагаа явуулж буй гадны компанийн газар ашиглалтын судалгаа
Хавсралт № 3	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлд танилцуулаагүй, хуралдаанаар хэлэлцүүлээгүй, зөвшөөрөл, шийдвэргүй асуудлын судалгаа
Хавсралт № 4	Хэрэгжээгүй гэрээний заалтын судалгаа
Хавсралт № 5	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-д “Ачит Ихт” ХХК-иас шилжүүлсэн ашиглалтын төлбөрийн судалгаа
Хавсралт № 6	“Эрдмин” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид, дүрмийн санд оруулсан хувь хэмжээ, хөрөнгийн өөрчлөлтийн судалгаа
Хавсралт № 7	Газрын төлбөрийн ногдуулалтын судалгаа



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын аудитын ажлын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын нэр	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын код	УАГ-ГАГ/2017/01-ДА
Аудитын зорилт	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, түүний үр дүнг шалгаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад давтан аудитын зорилт чиглэгдэнэ. ОХУ-ын Тооцооны танхим, Монгол Улсын Үндэсний аудитын газраас 2014 онд “Эрдэнэт үйлдвэр ХХК-д оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн удирдлага”-д хийсэн хамтарсан шалгалтаар гэрээ, хэлэлцээр, хууль, дүрэм, журмын заалтыг зөрчсөн 11, ногдол ашигтай холбоотой 2, дотоод хяналттай холбоотой 4, худалдан авалттай холбоотой 5, үр ашиггүй хөрөнгө оруулалт, зардалтай холбоотой 7, нийт 29 зөрчлийг илрүүлж, холбогдох байгууллагуудад захидал хүргүүлж, УАГ-аас 2013 онд “Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн санхүүгийн зарим үйл ажиллагаа”-нд хийсэн эрсдэлийн аудитаар гэрээ, хэлэлцээр, хууль, дүрэм, журмын заалтыг зөрчсөн 1, худалдан авалттай холбоотой 4, үр ашиггүй хөрөнгө оруулалт, зардалтай холбоотой 7, дотоод хяналттай холбоотой 3, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 7, нийт 22, УАГ-аас 2013, 2014 онд “Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудит”-аар гэрээ, хэлэлцээр, хууль, дүрэм, журмын заалтыг зөрчсөн 5, худалдан авалттай холбоотой 6, үр ашиггүй хөрөнгө оруулалт, зардалтай холбоотой 8, дотоод хяналттай холбоотой 6, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 24, нийт 49 заалт бүхий зөвлөмжийг тус тус өгсөн байна. Дээр дурдсан хамтарсан шалгалт болон аудитаас өгсөн зөвлөмж, илэрсэн асуудлуудад дүн шинжилгээ хийсний дүнд материаллаг шинжтэй, удаа дараа давтагдаж байсан, ач холбогдол ихтэй гэж үзсэн дараах 4 асуудлыг сонгон авч, энэ удаагийн давтан аудитад хамруулан шалгахад аудитын дэд зорилтуудыг тодорхойлсон. Үүнд: - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан эсэх; “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн эсэх; - Бүтээгдэхүүн борлуулах, экспортод гаргах үнийг зохистой тогтоож, үр ашиггүй хөрөнгө оруулалт, зардлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлсэн эсэх; “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.
Хамарсан хүрээ	Аудитад “Эрдэнэт үйлдвэр” ХХК, түүний Төлөөлөн удирдах зөвлөл, “Эрдмин” ХХК, “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК зэрэг хүдэр боловсруулах үйл ажиллагаа явуулж буй компаниуд, аудиттай холбоотой асуудлаар нэмэлт тодруулга авах зорилгоор Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, Орхон аймгийн Газрын алба, Гаалийн газар зэрэг байгууллагуудыг хамруулан 2015-2016 он болон 2017 оны 3 дугаар улирлын байдлаар шалгалаа.
Аудитын арга зүй	Аудитыг Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагыг ашиглан аудитын дэд зорилтуудын хүрээнд эрсдэлтэй асуудлыг түүвэрлэн шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асууж тодруулах, лавлагаа, тайлбар авах, судалгаа, баримт материал, мэдээлэл, нотлох зүйлсийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, тоон мэдээллийг тулган баталгаажуулах арга зүйг ашиглан гүйцэтгэв.



Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитад дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд: - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; - Компанийн тухай хууль; - Ашигт малтмалын тухай хууль; - Иргэний хууль; - Газрын тухай хууль; - Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”; - Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”; - “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2013 оны А/476 дугаар тушаалаар баталсан “Эрдэнэт үйлдвэр ХХК-д бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах түр журам”, 2015 оны “Онцгой комисс байгуулах тухай” А/13 дугаар тушаал, “Онцгой комисс”-ын дарга, Үйлдвэрлэл хариуцсан дэд захирлын 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдөр баталсан “Онцгой комиссын ажиллах журам”; - Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”; - Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дүрэм (Зөвлөлийн 2007 оны 38 дугаар хуралдаан, Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 01 дүгээр тогтоолоор баталсан); - Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Зөвлөлийн тухай журам”;
Аудитын бүрэлдэхүүн	Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Долгорсүрэн, аудитор М.Наранжаргал, Б.Хаш-Эрдэнэ, Чанарын баталгаажуулалтын албаны ахлах аудитор И.Туяа, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан нар гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитын явцад дараах хүндрэл бэрхшээл тулгарсан болно. Үүнд: 1) 2003 онд батлагдсан Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.4¹, 2015 онд батлагдсан Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1², 6.7³ дахь заалтыг зөрчин 2015-2016 оны санхүүгийн тайлан, тодруулга, санхүүгийн тайлангийн шинжилгээ, бизнес төлөвлөгөө, газар, хэлтсүүдийн үйл ажиллагааны тайлан, зарим гэрээ, Зөвлөлийн хурлын тэмдэглэл зэрэг баримтыг Орос хэл дээр үйлдсэн тул танилцах, орчуулга хийлгэхэд хугацаа шаардсан. 2) Талбарын ажлын явцад холбогдох газар, хэлтэс, албан тушаалтнаас аудитад шаардлагатай баримт материал авахаар нийт 22 удаа “Санамж бичиг” хүргүүлсэн боловч дор дурдсан шалтгаанаар баримт, материалыг бүрэн гүйцэд ирүүлээгүй, зарим баримт, материалыг огт гаргаж өгөөгүй зэргээс шалтгаалан хүлээлт үүссэн. Тухайлбал: • Баримт материалыг холбогдох албан тушаалтанаас шууд авах боломжгүй, удирдлагын хэд хэдэн шат дамжлагаар хянагдаж, зарим баримтыг дутуу өгсөн, • Архиваас баримт авах зөвшөөрөл авахад хэд хэдэн шат дамжлага дамждагаас 2-3 хоног зарцуулсан, • Баримт архивт шилжсэн, ТУЗ-ийн зөвшөөрөл авах хэрэгтэй, нууцын жагсаалтад орсон тул Хууль, эрх зүйн газраас зөвшөөрөл авах шаардлагатай гэх мэт.

¹ 5.4.Монгол улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөрийн холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтөлнө.

² 6.1.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт;

³ 6.7.Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын хуулийн этгээд, төрийн бус байгууллага Монгол Улсын төрийн байгууллага, иргэнтэй монгол хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичиг, мэдээллийг монгол хэлээр үйлдэнэ.



- Аудитаар судлагдаж байгаа асуудлын хүрээнд холбогдох албан тушаалтантай уулзалт ярилцлага хийх, тодруулга авах шаардлага гарч байсан ч зарим албан тушаалтан гадаадад томилолтоор явсан, чөлөө авсан гэх шалтгаанаар ярилцлага хийх, тайлбар тодруулгыг бүрэн гүйцэд авах боломж бүрдээгүй.
- 3) Аудитад шаардлагатай дор дурдсан баримт бичгийг “Санамж бичиг”-ээр удаа дараа гаргаж өгөхийг хүссэн боловч аудитын явцад ирүүлээгүй тул асуудлыг нягталж үзэх боломжгүй байлаа. Үүнд:
- “Морьт Эксплорейшн” ХХК-тай 2014.04.21-ний өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”,
 - “Эрдэнэт” концерн, Америкийн “Ар Си Эм” корпорацийн хооронд 1994.3.14-ны өдөр байгуулсан гэрээ,
 - “Эрдмин” ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн 1995 онд АНУ-ын “BKS Engineers Inc” компанийн боловсруулсан ТЭЗҮ,
 - “Ачит Ихт” ХХК-тай 2013.06.30-ны өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”,
 - “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хууль, эрх зүйн газраас 2015-2017 онд бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний нэгдсэн жагсаалт




Ерөнхий мэдээлэл

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2015-2017 онд гүйцэтгэлээр нийт 92.3 сая тонн хүдэр олборлож, 82.7 сая тонн хүдэр боловсруулж, 1,528.1 мянган тонн зэсийн баяжмал, 14.7 мянган тонн молибдений баяжмал үйлдвэрлэсэн байна.

Дүрслэл № 1

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт




Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015, 2016 он, 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан

Жилд дунджаар 30.8 сая тонн хүдэр олборлож, 27.6 сая тонн хүдэр боловсруулж, 530.4 мянган тонн зэсийн баяжмал, 4.9 мянган тонн молибдений баяжмал үйлдвэрлэж байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК 2015 онд 9.1 тэрбум төгрөгийн, 2017 оны 3 дугаар улиралд 184.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 2016 онд 123.6 тэрбум төгрөгийн алдагдалтай⁴ ажиллажээ.

Дүрслэл № 2

Нийт орлого, зардал, цэвэр ашгийн судалгаа (тэрбум төгрөгөөр)



Хүснэгт № 1

Улс орон нутгийн төсөвт төлсөн татварын судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 оны 3-р улирал
Улсын төсөвт	304.0	149.5	348.5
Орон нутгийн төсөвт	77.0	43.4	32.8
Нийт дүн	381.0	192.9	381.3

Эх сурвалж: Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлан

Улс болон орон нутгийн төсөвт 2015 онд нийт 381.0 тэрбум төгрөг, 2016 онд 192.9 тэрбум төгрөг, 2017 оны 3 дугаар улиралд 381.3 тэрбум төгрөг төлжээ.

Орон нутгийн төсөвт 2015-2017 онд дунджаар төлсөн нийт татварын 17.1 хувийг, улсын төсөвт 82.9 хувийг тус тус төлсөн байна.

⁴ Олон Улсын Арбитрын шүүхээс 2016 оны 9 дүгээр сард ӨАБНУ-ын Стандарт банканд нийт 99.0 сая ам.доллар төлөх шийдвэр гарснаас 44.0 сая ам.долларыг хүлээн зөвшөөрхгүйгээр шийдвэрлэж, 51.0 сая ам.доллар буюу 126.9 тэрбум төгрөгийг болзошгүй өр төлбөрөөр, Медипас ХХК-д шилжүүлсэн эд хөрөнгийн авлагын үнэ цэнийн бууралтын 32.6 тэрбум төгрөгийг тус тус бүртгэсэн.

**БҮЛЭГ 1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хуулийг зөрчиж иржээ**

1.1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2015-2017 онд нийт 1,017.8 тэрбум төгрөгийн 1510 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулжээ. Үүнээс бараа 92.7 хувь буюу 943.3 тэрбум төгрөг, барилга, их завсарын ажил 6.6 хувь буюу 67.3 тэрбум төгрөг, зөвлөх үйлчилгээ 0.7 хувь буюу 7.2 тэрбум төгрөгийг тус тус эзэлж байна.

Хүснэгт № 2

2015-2017 онд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын судалгаа

Бараа, ажил, үйлчилгээний төрөл	2015 он		2016 он		2017 оны 3-р улирал		(тэрбум төгрөгөөр)	
	гэрээний тоо	мөнгөн дүн	гэрээний тоо	мөнгөн дүн	гэрээний тоо	мөнгөн дүн	гэрээний тоо (1+3+5)	мөнгөн дүн (2+4+6)
<i>A</i>	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	<i>7</i>	<i>8</i>
Бараа	394	300.7	385	392.0	326	250.6	1,105	943.3
Их барилгын ажил	77	32.0	77	14.8	223	20.5	377	67.3
Зөвлөх үйлчилгээ	9	3.5	6	1.4	13	2.3	28	7.2
Нийт дүн	480	336.2	468	408.2	562	273.4	1,510	1,017.8

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хангамжийн хэлтэс, Их барилгын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэсээс ирүүлсэн судалгаа

Худалдан авах ажиллагаанд баримтлах зарчмыг мөрдөөгүй байна

1.2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015-2017 оны бизнес төлөвлөгөөнд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах аргыг хуульд нийцүүлэн төлөвлөж, батлуулаагүй, нийт худалдан авалтын 92.8 хувь /944.2 тэрбум төгрөг/-ийг шууд гэрээ байгуулах аргаар, 5.1 хувь /52.0 тэрбум төгрөг/-ийг харьцуулалтын аргаар, 2.1 хувь /21.5 тэрбум төгрөг/-ийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна. (Хавсралт № 1)

1.3. Энэ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, тус хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4⁵ дэх заалттай нийцэхгүй байна.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁶ дахь заалтыг үндэслэн шууд гэрээ байгуулахдаа гүйцэтгэгчийн ерөнхий нөхцөлийг магадлах, санхүүгийн чадавхийг үнэлэх, техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх зэргээр хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг үнэлж, сонголт хийсэн талаар ямар нэгэн баримт бичиг үйлдээгүй, тус хуулийн 34.3⁷-т заасны дагуу Сангийн яаманд хандсан баримт бичиг байхгүй байв.

1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1⁸ дахь заалтыг зөрчин тендерийн баталгаа гаргуулахгүйгээр 2015-2017 онд хийгдсэн нийт гэрээний 24.3 хувийг гэрээний үнийн дүнгийн 30-100 хүртэл хувийн урьдчилгаа олгохоор гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж, их хэмжээний авлага үүсэх эрсдэлийг бий болгосон байна.

1.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2⁹, 44.4¹⁰ дахь заалтыг зөрчин 2015 онд бараа худалдан авах нийт

⁵ “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”

⁶ 34.2. Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

⁷ 34.3. Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

⁸ 20.1.Захиалагч энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, 100 сая төгрөгөөс дээш өртөгтэй зөвлөх үйлчилгээ худалдан авах тендэрт оролцогчоос тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана.

⁹ 44.2.Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө.

¹⁰ 44.4.Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.



гэрээний 20 хувь, 2016 онд 31 хувь, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 21 хувьд нь урьдчилгаа олгож, 2015 онд 37.1 тэрбум төгрөг, 2016 онд 40.6 тэрбум төгрөг, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 40.2 тэрбум төгрөгийн авлага үүсгэжээ.

Агуулахын үлдэгдлийг зохистой түвшинд хянаж нөөцийг тооцохгүйгээр худалдан авалт хийж, ашиглалтгүй болон илүүдэл хөрөнгө бий болгожээ

1.7. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн Монголын хэсгийн 2013 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий захирлын 2013 оны А/476 дугаар тушаалаар баталсан “Эрдэнэт үйлдвэр ХХК-д бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах түр журам”-ын 4.1-т “Нэгдсэн захиалгад харьяа цех, нэгжээс санал ирүүлэхдээ тухайн барааны техникийн нөхцөл, ажил үйлчилгээг өөрсдийн шаардлагад нийцүүлэн тусгасан байна. Тухайн захиалгыг Техникийн хэлтэс хянаж баталгаажуулна”, 4.2-т “Захиалга бүрийн үнийн саналыг Эдийн засаг, маркетингийн хэлтсийн зах зээлийн судалгааг үндэслэн тодорхойлно”, 2.1¹¹ дэх заалтыг үндэслэн бараа, ажил, үйлчилгээний захиалгыг Техникийн хэлтэс хянаж, сар бүр “Онцгой комисс”-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэдэг байна.

1.8. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн агуулахын үлдэгдлийг бараа, материалын нэр төрлөөр ангилж үзвэл дунджаар нийт үлдэгдлийн 42.1 хувийг сэлбэг, 32.0 хувийг үндсэн технологийн материал, 16.6 хувийг туслах материал, 5.1 хувийг бусад материал, 4.2 хувийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйл эзэлж байна.

Хүснэгт № 3

Агуулахын үлдэгдлийн судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Огноо	Үндсэн технологийн материал	Туслах материал	Сэлбэг	БҮТЭЗ	Бусад	Нийт бараа материалын дүн
2015 он	49.8	28.3	59.4	6.8	10.3	154.4
2016 он	56.1	27.5	77.7	7.2	7.2	175.7
2017 оны 9 сарын 30-ны байдлаар	55.3	27.7	76.1	6.9	8.6	174.6

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлангийн тодруулга

1.9. МУИС-ийн эрдэм шинжилгээний баг 2014 онд агуулахын зохистой нөөцийг тооцоолж, багадаа 110.0 тэрбум, ихдээ 130.0 тэрбум төгрөг байх нь оновчтой гэж зөвлөсөн боловч агуулахын зохистой нөөцийн хамгийн их дүнгээс үйлдвэрийн агуулахын нийт үлдэгдэл 2015 онд 18.7 хувиар, 2016 онд 35.2 хувиар, 2017 онд 34.3 хувиар тус тус хэтэрч иржээ.

1.10. Агуулахын эргэлтийн хөрөнгийн насжилтад судалгаа хийхэд дунджаар нийт эргэлтийн хөрөнгийн 66.6 хувь нь 1 хүртэл жил, 19.3 хувь нь 1-3 жил, 14.1 хувь нь 3-аас дээш жил хадгалагдсан байна.

1.11. Судалгаанаас харахад 1-ээс дээш жил хадгалагдаж байгаа хөрөнгүүд 2015 оноос өсч, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 70.5 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 40.8 хувьд хүрчээ.

1.12. Энэ нь агуулахын үлдэгдлийг зохистой түвшинд хянаагүй, нөөцийг тооцохгүйгээр их хэмжээний хөрөнгийг худалдан авч нөөцөлж, ашиглалтгүй хөрөнгийг бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 4

Эргэлтийн хөрөнгийн насжилтын судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Хадгалагдсан хугацаа	2015.12.31		2016.12.31		2017.9.30	
	мөнгөн дүн	хувь	мөнгөн дүн	хувь	мөнгөн дүн	хувь
А	1	2	3	4	5	6
1 жил хүртэл	111.9	72.4	119.7	68.1	102.4	59.2
1-3 жил	17.4	11.3	32.8	18.7	48.2	27.9
3-аас дээш жил	25.2	16.3	23.3	13.3	22.3	12.9
Нийт дүн	154.5	100.0	175.8	100.0	172.9	100.0

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хангамжийн хэлтсийн ажлын тайлан

¹¹ Компанийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа захиалагч цех, нэгжүүдээс Материал техникийн хангамжийн хэлтэс, Их барилгын хэлтэс, Хөгжлийн хэлтэс зэрэг холбогдох хэлтсүүдэд ирүүлсэн захиалгыг компанийн барааны үлдэгдэл, Зөвлөлийн хурлын шийдвэртэй тулган нэгтгэж, тухайн оны нэгдсэн захиалгыг Ерөнхий захирлын чиглэл хариуцсан орлогчтой зөвшилцөн Ерөнхий захирлаар батлуулна. Зайлшгүй тохиолдолд нэгдсэн захиалгад нэмэлт өөрчлөлт оруулах ба нэмэлт захиалга нь шинжлэх ухаан техник инновацийн комиссын шийдвэрийг үндэслэн Ерөнхий захирал баталсан тохиолдолд хүчинтэй байна.



Хүснэгт № 5

Ашиглагдахгүй хөрөнгийн үлдэгдлийн судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Бараа, материалын нэр	мөнгөн дүн		Нийт дүнд эзлэх хувь	
	2017.1.1	2017.9.30	2017.1.1	2017.9.30
A	1	2	3	4
Үндсэн хөрөнгө	1.8	1.8	28.1%	30.0%
Эргэлтийн хөрөнгө	4.6	4.2	71.9%	70.0%
Нийт дүн	6.4	6.0	100.0%	100.0%

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” Хангамжийн хэлтсийн ажлын тайлан

1.13. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2017 оны эхэнд 6.4 тэрбум төгрөгийн ашиглагдахгүй хөрөнгийн үлдэгдэлтэй, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 6.0 тэрбум төгрөг болж, 0.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

1.14. Ашиглагдахгүй байгаа нийт хөрөнгийн 30 хувь нь үндсэн хөрөнгө, 70 хувь нь эргэлтийн хөрөнгө эзэлж байна.

1.15. Агуулахын зохистой нөөцөд тулгуурлан захиалгыг хянаж байх, илүүдэл болон ашиглалтгүй хөрөнгийг эргэлтэд оруулах, ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулах үлдэгдлийг бууруулах талаар зохион байгуулж буй ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа хууль, журамд нийцэхгүй байна

2.1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 11,353.7 га газрыг 20 жилийн хугацаатай ашиглуулах шийдвэрийг тус аймгийн Засаг даргын 2010 оны 169 дугаар захирамжаар гаргасан байна. Тус үйлдвэр 2017 оны 6 дугаар сарын 8-ны байдлаар нийт 11,453.7 га газрыг ашиглаж байна.

2.2. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ашиглалтын MV-000011, №0005395, хайгуулын XV002606 дугаар тусгай зөвшөөрөлтэй газарт хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, үйлдвэр байгуулахаар туршилт, судалгааны ажлыг явуулах зорилгоор “Эрдмин” ХХК, “Ачит ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт Эксплорейшн” ХХК-иуд гэрээ байгуулан нийт 296.2 га газрыг ашиглан дараах үйл ажиллагааг явуулж байна. (Хавсралт № 2) Үүнд:

1. “Ачит Ихт” ХХК балансын бус хүдрийн 2 дугаар овоолгыг ашиглан уусгах технологиор боловсруулалт хийж, жилд 10000 тн катодын цэвэр зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2011-2013 онд байгуулсан.
2. “Эрдмин” ХХК исэлдсэн болон холимог хүдрийн 2А овоолгыг ашиглан нуруудан уусгах технологиор боловсруулалт хийж, жилд дунджаар 2920 тн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 1996 онд байгуулсан.
3. “Зэс-Эрдэнийн хувь” ХХК исэлдсэн хүдрийн 8а, 12 дугаар овоолгуудыг ашиглан нуруудан уусгах технологиор катодын зэс гаргах үйлдвэр байгуулах гэрээ байгуулж, туршилт судалгааны ажлыг явуулж байна.
4. “Морьт Эксплорейшн” ХХК Баяжуулах фабрикийн урсгал болон хуримтлагдсан хаягдлыг гүйцээн боловсруулж зэс, молибдени гаргах боломжийг судлах, үйлдвэр байгуулах гэрээ байгуулж, судалгааны ажлыг хийж байна.

2.3. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн 27, 33, 36, 43, 44, 45 дугаар хуралдаанаар үйлдвэрийн хүдэр олборлох явцад үүссэн исэлдсэн болон холимог, балансын бус хүдрийн овоолгыг ашиглах боломжийг судлах, хүдэр боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах, үйлдвэрлэлийн туршилт явуулж, үр дүнг танилцуулах, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө, хувь эзэмшлийн асуудлыг хэлэлцүүлэх чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгч байжээ.

Хүснэгт № 6

Зөвлөлийн хуралдаанаар өгсөн чиглэлийн судалгаа

Зөвлөлийн хуралдааны дугаар	Хуралдаанаас өгсөн чиглэл
1998 оны 27 дугаар ээлжит бус хуралдаан	Үйлдвэр “Эрдмин” ХХК-д 1994-1998 онд нийт 3.4 сая ам.долларын үйлчилгээ үзүүлснээс 1998 онд 0.514 сая ам.долларын үйлчилгээ талуудын зөвшөөрөлгүй хийгдсэн, тус компанид зайлиггүй шаардлагатай хөрөнгө оруулалт хийх талаар танилцуулаагүй, талууд “Эрдэнэт концерн” ХХК-иар дамжуулан “Эрдмин” ХХК-ийн 25 хувийг эзэмшиж буй баримт бичигтэй танилцаагүй тул цаашид хамтрах боломжгүй, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг түргэн эргүүлж авах асуудлыг шийдвэрлэх.
2003 оны 33 дугаар хуралдаан	Исэлдсэн болон холимог сульфидын хүдрээс SX-EW технологиор цэвэр зэс үйлдвэрлэх хагас үйлдвэрийн туршилт явуулж, үр дүнг танилцуулах.
2006 оны 36 дугаар хуралдаан	Балансын бус хүдэр, сульфидын хүдрээс катодын зэс гаргах үйлдвэрлэлийн технологийн туршилтыг үргэлжлүүлэх, Овоолгын аргыг автоклавын аргатай хослуулж жилд 30 мянган тонн катодын цэвэр зэс гаргах хүчин чадалтай үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах.
2010 оны 43 дугаар хуралдаан	Үйлдвэрийн балансын гадуурх хүдрийн овоолгыг ашиглах боломжийг судлах.
2010 оны 44 дугаар хуралдаан	Хэрэгжих шатандаа байгаа ажилд ...Оросын “РИБС” ХХК-тай шинжлэх ухаан-судалгааны ажлын “Хүдрийн эрдсийн техногенийн флотацийн технологи боловсруулах, нэвтрүүлэх” гэрээ байгуулсан, “Ачит Ихт” ХХК-тай балансын гадуурх хүдрээс ангижруулалтын аргаар зэс гарган авах үйлдвэрлэлийн туршилтын гэрээ байгуулсан.
2011 оны 45 дугаар хуралдаан	“Зэс-Эрдэнийн хувь” ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ-д үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсэг тус ТЭЗҮ-ийг лабораторийн туршилт судалгаа, хагас үйлдвэрлэлийн туршилтуугээр боловсруулсан тул техник эдийн засгийн хувьд үндэслэлгүй хэмээн дүгнэсэн.

2.4. Зөвлөлийн Монголын хэсгээс 2010 оны 12 дугаар сарын 6-ны өдөр “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай хамтран катодын зэсийн үйлдвэр байгуулах төслийг танилцуулах хүсэлтийг Зөвлөлийн Оросын хэсэгт хүргүүлсэн боловч тус төслийг мэргэжлийн байгууллагын урьдчилсан дүгнэлт гаргуулаагүй, технологи, лабораторийн болон хагас үйлдвэрийн туршилт хийгээгүй, хөрөнгө оруулалт бүрдүүлэх үндэслэл хангалтгүй байгаа тул Зөвлөлийн 44 дүгээр хуралдаанаар хэлэлцэх боломжгүй гэж үзэн холбогдох зөвшөөрлийг олгоогүй байна.

Гүйцэтгэх удирдлага Зөвлөлийн шийдвэргүйгээр хүдэр боловсруулах үйлдвэр байгуулсан байна

2.5. Төслийн танилцуулга, ТЭЗҮ, үйлдвэрлэлийн туршилт, эдийн засгийн үр ашгийн судалгаа, тооцооллыг Зөвлөлд танилцуулаагүй, хуралдаанаар хэлэлцүүлээгүй, шийдвэр, зөвшөөрөл аваагүйгээр “Ачит Ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт Эксплорейшн” ХХК-тай гэрээ



байгуулан хүдэр боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулалт хийж, үйлдвэр байгуулж, үйлдвэрлэл явуулсан байна. (Хавсралт № 3)

2.6. Энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16-д “Энэ хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох”, 76.1.17-д “Энэ хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох” гэж заасныг гүйцэтгэх удирдлага зөрчиж, Зөвлөлд бүрэн эрхийн дагуу зөвшөөрөл, шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

2.7. Үйлдвэрийн Дүрмийн 11.1¹²-т заасныг зөрчин Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлээгүй байхад зөвхөн Зөвлөлийн Монголын хэсгийн шийдвэрийг үндэслэн дүрмийн 12.3-т “Ерөнхий захирал¹³ нь компанийн үйл ажиллагааг Зөвлөлийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдана”, 12.4-т “Компанийн гүйцэтгэх удирдлага¹⁴ нь Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг зохион байгуулна” гэж заасныг зөрчин хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах талаар Зөвлөлийн зөвшөөрөл, шийдвэргүйгээр дур мэдэн их хэмжээний хэлцэл хийж, гэрээг байгуулсан байна. Үүнд:

“Ачит Ихт” ХХК-тай:

- 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан 5/225-10 дугаар “Эрдэнэт”-ийн овоолгийг ашиглан геодометаллургийн аргаар катодын зэс үйлдвэрлэх бүрэн хэмжээний үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх гэрээ”;
- 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан АИ-13/02 дугаар “Хамтран ажиллах гэрээ”;
- 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “ГЭРЭЭ” №5/199-15 дугаар гэрээ,

“Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай:

- 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан 5/096-13 дугаар “Хамтран ажиллах гэрээ”;
- 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан 5/277-15 дугаар “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах” 20 жилийн хугацаатай гэрээ,
- 2015 онд байгуулсан “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах” 5/277-15 дугаар гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Зэс эрдэнийн хувь” ХХК болон “Ферростаал Монголиа” ХХК-тай “2016 оны 10 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан “Исэлдсэн хүдрийн 8А, 12 дугаар овоолгуудаас технологийн туршилтын дээж авах” 5/279-14 дугаар гэрээ,

“Морьт Эксплорейшн” ХХК-тай:

- 2012 оны 07 дугаар сарын 18-ний өдөр байгуулсан “Хамтран ажиллах” 5/251-12 дугаар гэрээ (хаягдлын аж ахуйд хуримтлагдсан хаягдлыг ашиглах эрхийг 30 жилийн хугацаатай олгосон),
- 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”,
- 2016 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах” 5/231-16 дугаар гэрээ.

2.8. Төрийн өмчийн хорооны 2013 оны 1а/2170, 1а/3777, 2014 оны 1а/492 дугаар албан бичгээр дараах асуудлыг Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх чиглэлийг үйлдвэрийн гүйцэтгэх удирдлагад өгсөн боловч хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- Зөвлөлийн Монголын хэсгийн 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрт дурдсан “...Зөвлөлийн 43 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор “Ачит ихт” ХХК-тай 2010 онд байгуулсан №5/225-10 дугаар гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг дүрмийн дагуу танилцуулах,
- “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай 2013 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, 2013 оны 07 дугаар сарын 26-ны дотор танилцуулах,
- “Морьт Эксплорейшн” ХХК-тай байгуулсан “Хаягдлыг дахын боловсруулж бүтээгдэхүүн үйлдэрлэх шинэ технологи нэвтрүүлэх” гэрээ, шингэн хаягдлыг ашиглах компанийн бодлогыг боловсруулах, хаягдлыг үнэлэх асуудлыг судлах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэх.

2.9. Үйлдвэрийн Ерөнхий захирлын 2014 оны 14 дүгээр захирамжаар байгуулсан “Хамтарсан ажлын хэсэг”-ээс “Ачит Ихт” ХХК-тай байгуулсан 2010 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 5/225-10 дугаар гэрээний хэрэгжилт, үйлдвэрийн ТЭЗҮ-д үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар дараах санал, дүгнэлт гаргасан боловч Зөвлөлд танилцуулаагүй байна. Үүнд:

- “Ачит Ихт” ХХК-ийн барьсан үйлдвэрийн ТЭЗҮ нь үндэслэл муутай хийгдсэн, эдийн засгийн эрсдэл өндөр байх магадлалтай маш муу төсөл,
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК технологийн үзүүлэлтийн эрсдэлийг хамтарч үүрэх шаардлагагүй, учир нь үйлдвэртэй зөвшилцөлгүй ТЭЗҮ-ийг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн,
- ТЭЗҮ-д технологийн болон байгаль орчны эрсдэлийг үндэслэл муутай тооцоолсон тул үйлдвэрийн үйл ажиллагаанд “Эрдэнэт үйлдвэр” ХХК хувь эзэмшиж оролцох шаардлагагүй,

¹²11.6 ...Зөвлөлийн хурлын шийдвэр нь компанийн 2 хувь нийлүүлэгчийн бүх төлөөлөгчид оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцогдоно...”

¹³ Ерөнхий захирлын эрх хэмжээнд Зөвлөлийн эрх хэмжээнд хамааруулсанаас бусад компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдахтай холбогдсон бүх агуудал хамаарна.

¹⁴ Ерөнхий захирал, ерөнхий захирлын 1-р орлогч, ерөнхий захирлын орлогчид болон ерөнхий нягтлан бодогчоос бүрдэнэ.



- “Ачит ихт” ХХК-тай Иргэний хуулийн дагуу “Ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан ажиллах нь зүйтэй гэж дүгнэсэн байна

2.10. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь “Ачит Ихт” ХХК-ийн овоолгон уусгах технологи ашиглан катодын зэс боловсруулах үйлдвэр /2011 оны 5 сараас барьж эхлэн 2013 оны 10 дугаар сард бүрэн ашиглалтад оруулсан/ байгуулсныг Зөвлөлийн Оросын хэсэгт танилцуулаагүй, үйлдвэрлэл явуулсныг мэдэгдээгүй талаар хяналт шалгалтын комиссын дүгнэлтэд дурдсан байна.

2.11. Зөвлөлийн Оросын хэсгийн хяналт шалгалтын комиссын Оросын хэсгийн “Үйлдвэрийн 2013 оны үйлдвэрлэл, бизнес, санхүүгийн үйл ажиллагаа”-нд хийсэн аудитын дүгнэлтэд “...үйлдвэрийн талбай дээр тогтоосон хэм хэмжээгээр төсөл хэрэгжиж эхлэхэд Оросын талын хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авалгүйгээр балансын гадуурх овоолгыг ашиглан овоолгон уусгах технологиор жилд 10000 тонн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг “Ачит Ихт” ХХК 2010-2013 онд байгуулсан нь алдаа зөрчилтэй, хууль, санхүү, эдийн засаг, техникийн үндэслэлүүдийг танилцуулаагүй, баталгаажаагүй” хэмээн цохон тэмдэглэж, үйлдвэрийн гүйцэтгэх удирдлагад дараах зөвлөмжийг өгсөн ч хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Балансын гадуурх овоолгыг ашиглан овоолгон уусгах технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн хууль, санхүү, эдийн засаг, техникийн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах,
- Хувьцаа эзэмшигчдийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, балансын гадуурх овоолго болон байгаль орчныг хамгаалах асуудлыг тусгасан, ашиглалтын нэгдсэн бодлого боловсруулах.

2.12. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага үйлдвэрийн Дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “...Жилийн хуралдаанаас бусад Зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн шийдвэрээр, түүнчлэн Ерөнхий захирлын саналаар зөвшилцсөн хугацаанд явуулна” гэж заасныг хэрэгжүүлэх талаар санаачлагатай байгаагүй, Зөвлөлийн шийдвэрлэх асуудал 11.6.8¹⁵, 11.6.9¹⁶, 11.6.12¹⁷, “Зөвлөлийн тухай журам”-ын Зөвлөлийн онцгой эрх хэмжээний асуудал 2 дахь хэсгийн 2.6-д “....компани Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаадад хуулийн этгээдэд оролцох тухай шийдвэрийг батлах, Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд зааснаар бусад шийдвэр гаргах” гэж заасныг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг гүйцэтгэх удирдлагаас Зөвлөлд бүрдүүлж өгөөгүй нь дээрх зөрчлүүд гарах нөхцөлийг бий болгосон байна.

2.13. Иймд Зөвлөлийг үйлдвэрийн Дүрэм болон Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16¹⁸, 76.1.17¹⁹, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1²⁰, 5.5²¹, Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4²²-т нийцүүлэн холбогдох хэлцэлийн шалгуурыг тогтоох, зөвшөөрөл олгох, үйлдвэрт ашигтай үр өгөөжтэй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлээгүй нь гүйцэтгэх удирдлага сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй байж болзошгүй тул холбогдох гэрээг хууль, хяналтын байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна.

ЭБМЗ-өөр хянуулаагүй, дүгнэлтгүй ТЭЗҮ-ийг ашиглан хүдэр боловсруулах үйлдвэрийг байгуулж, үйлдвэрлэл, туршилт судалгааны ажлыг явуулсаар байна

2.14. Аудитын явцад балансын бус хүдэр, исэлдсэн болон холимог хүдрийн овоолгыг ашиглан хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хянуулаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- 2011 онд Бээжин хотын “Уул уурхай, металлургийн ерөнхий судалгааны хүрээлэн”-гийн боловсруулсан “Ачит Ихт” ХХК-ийн овоолгон уусгах технологиор катодын зэс ялгах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хянуулаагүй, түүнийг ашиглахыг зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй, хүлээн авсан дүгнэлт гараагүй байхад үйлдвэрлэлийг эхэлсэн.

¹⁵ Их хэмжээний хэлцлийн шалгуурыг Монголын хууль тогтоомжийн дагуу тогтоож энэ төрлийн хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох,

¹⁶ Сонирхолын зөрчил бүхий хэлцлийн шалгуурыг Монголын хууль тогтоомжийн дагуу тогтоож, энэ төрлийн хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох.,

¹⁷ Охин компани байгуулах, ...Монгол улс болон гадаадад байгаа хувьцаат компани болон аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах асуудлаар компанийн гүйцэтгэх удирдлагаас гаргасан холбогдох шийдвэрийг батлах,

¹⁸ “энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;”

¹⁹ “энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;”

²⁰ Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн.,

²¹ Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

²² Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно

- “Морьт Эксплорешн” ХХК-ийн Баяжуулах фабриккийн урсгал хаягдлаас зэс, молибдени гаргах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хэзээ, ямар байгууллага боловсруулсан нь тодорхойгүй, ЭБМЗ-өөр хянуулаагүй,
- “Эрдмин ХХК-ийн катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, үйлдвэрийн зураг төслийг 1995 онд АНУ-ын “BKS Engineers Inc” компани боловсруулсан /аудитын явцад ТЭЗҮ-ийг ирүүлээгүй тул нарийвчлан судлах боломж бүрдээгүй/ гэх боловч архивт байхгүй, Ашигт малтмалын улсын нөөцийн комиссоор /тухайн үеийн нэр/ хянуулсан эсэх нь тодорхойгүй байна.

2.15. “Ачит Ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-ийн хүдэр боловсруулах үйлдвэрийн нөөцийг улсын бүртгэлд бүртгээгүй байхад ТЭЗҮ-ийг боловсруулсан нь ашигт малтмал боловсруулах ТЭЗҮ²³-ийн үндсэн нөхцөл, шаардлагыг хангахгүй байна. Үүнд:

- “Ачит Ихт” ХХК овоолгон уусгах технологиор боловсруулалт хийх үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2014 онд “Жи Эт Эс Юу” ХХК-иар хийлгэж, ЭБМЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 60 дугаар дүгнэлтийг гаргуулсан ч, ЭБМЗ-өөс уг ТЭЗҮ-тэй танилцах хуудсанд “...нөөцийн бүртгэл байхгүй, яаж ямар үндэслэлээр тооцоо хийж ТЭЗҮ боловсруулсан..., ...улсын бүртгэлд нөөцгүй, иймд 90,0 сая тн зэсийг хаанаас ямар байдлаар тооцсон талаар дүгнэлт байхгүй... гэж дурдсан байна,
- “Зэс-Эрдэнийн хувь” ХХК холимог хүдрийг шүлтгүйжүүлэлт-хандлалт-электролизийн технологиор боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ²⁴-г 2014 онд Бээжингийн “Уул уурхай, металлургийн ерөнхий судалгааны хүрээлэн”, геологи, уул, уурхайн төслийн “Чин цэнлүү” ХХК-иар хийлгэж, ЭБМЗ-ийн 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 15-01-06 дугаар дүгнэлтийг гаргуулсан ч, ЭБМЗ-өөс уг ТЭЗҮ-тэй танилцах хуудаст “...овоолгын нөөц байгуулах, ЭБТЗ-ийн баталсан нөөцгүй байна, нөөцийн тооцоо хүснэгт байхгүй...” гэж дурдсан байна.

2.16. Энэ нь балансын бус хүдрийн нөөцийг улсын бүртгэлд бүртгээгүй байхад зөвхөн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн балансын бус хүдрийн овоолго, нөөцөд²⁵ тулгуурлан ТЭЗҮ-ийг боловсруулсантай холбоотой байна.

Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах зарим гэрээ хүчин төгөлдөр бус, холбогдох хуультай нийцүүлээгүй байна

2.17. Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт, судалгааны ажлыг явуулахаар “Ачит ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-иудтай байгуулсан гэрээний зарим заалтууд хэрэгжээгүй, гэрээ хүчин төгөлдөр биш байна. Тухайлбал:

“Ачит Ихт” ХХК-тай байгуулсан гэрээ:

- 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан 5/225-10 дугаар гэрээний 5.1²⁶,
- 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан АИ-13/02 дугаар гэрээний 12.1²⁷, 14.4²⁸,
- 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан №5/199-15 дугаар гэрээний үндэслэлд “...Монгол Улсын Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т “...Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно...” зөвлөлөөр дэмжигдэж, зөвлөлийн хурлаар батлуулснаар хүчин төгөлдөр болно гэж заасан ч гэрээний заалтууд хэрэгжээгүй,

“Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай байгуулсан гэрээ:

- 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 5/096-13 дугаар гэрээний үндэслэлд “...Зөвлөлийн Монголын хэсгийн 2012 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаас гаргасан шийдвэр нь Монголын талын байр суурь, компанийн дүрэмд заасны дагуу “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-иас тавьж буй асуудлаар гарах шийдвэр нь Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах учраас Оросын талын саналыг авч, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ТӨХ-ны Тамгын газрын даргын 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 16/919 дугаар албан бичгээр өгсөн чиглэл,
- 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 5/277-15 дугаар гэрээний 2.1-т ...Катодын зэс гарган авах үйлдвэрийг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 3 /гурван/ жилийн хугацаанд барьж байгуулна...гэж заасан ч одоогоор үйлдвэрийг барьж эхлээгүй²⁹,
- 2016 оны 10 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан 5/279-14 дугаар гэрээний 5.1-ын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д туршилт судалгааны үр дүнг танилцуулсан эсэх нь тодорхойгүй, гэрээний 7.1-ын дагуу дээж авагдаагүй, 7.2-ын дагуу 8а, 12 дугаар овоолгуудаас дээж авагдсан эсэх нь тодорхойгүй, гэрээний үйлчлэх хугацаа 2016.10.04-

²³ Улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцөд тулгуурлан уул уурхайн /ашигт малтмал олборлох баяжуулах, боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн уулын үйлдвэрийн техник технологийн сонголт тооцоо, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуй, эрх зүй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц,хангамж,нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоо, тайлбар хэсгээс бүрдэх техникийн иж бүрэн баримт бичгийг:

²⁴ Жилд 5000 тн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай

²⁵ БНМАУ-ын Улсын ашигт малтмалын нөөцийн сангийн комиссоос 1991 онд тогтоосон тоо дүнд үндэслэн

²⁶ Техник технологийн ба эдийн засгийн үр ашигтай байдал нь үйлдвэрлэлийн туршилтаар амжилттай болсон тохиолдолд Зөвлөлийн зөвшөөрлөөр дараах хувь хэмжээтэй өнгөт металлын үйлдвэр барьж байгуулахаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК овоолгын хүдрийг нийлүүлж, 34 хувийг, “Ачит Ихт” ХХК үйлдвэрийн барилгын ажлыг бүрэн санхүүжүүлж, 64 хувийг эзэмшихээр урьдчилсан байдлаар тохиролцсон.

²⁷ ... “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дүрмийн дагуу 2013 онд багтаан компанийн нөөцөлийн хурлаар батлуулна;

²⁸ ...зөвлөлийн хурлаас дэмжигдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно;

²⁹ “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Ферростал Монголиа” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээ



нд дуусгавар болсныг талууд дүгнээгүй, гэрээний 10.1.1-ын дагуу овоолгуудаас дээж авах ажлыг эхлүүлээгүй бол гэрээ цуцлах... гэж заасан ч гэрээг цуцалсан эсэх нь тодорхойгүй,

“Морьт эксплорейшн” ХХК-тай байгуулсан гэрээ:

- 2012 оны 07 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан 5/251-12 дугаар гэрээний 5-т “уг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд “Компани” судалгаа шинжилгээний ажлыг дуусгаж, ТЭЗҮ-ийг боловсруулж, үйлдвэр байгуулах асуудлыг шийдээгүй тохиолдолд энэхүү гэрээг хүчингүйд тооцно...” гэж заасан боловч судалгаа, шинжилгээний ажил дуусаагүй, ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хянагдаагүй, гэрээний үйлчлэх хугацаа 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр дууссан байхад гэрээний үр дүнг талууд дүгнээгүй байна.

2.18. “Морьт эксплорейшн” ХХК-тай байгуулсан 2016 оны 5/231-16 дугаар “Хамтын ажиллагааны гэрээ”-ний 9.1-д “Гэрээ нь гэрээ байгуулагч талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох ба 30 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна” гэж заасан нь Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 169 дүгээр захирамжаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д 20 жилийн хугацаатай газар ашиглуулахаар гаргасан шийдвэртэй зөрчилдөж байна.

Газар ашиглуулах гэрээний заалтууд Газрын тухай хуулийн зарим заалттай нийцэхгүй байна

2.19. Үйлдвэрийн удирдлага орон нутгийн Засаг даргатай зөвшилцөхгүйгээр³⁰ “Ачит Ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт Эксплорейшн” ХХК-иудтай “Газар ашиглах тухай”, “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” гэрээг байгуулсан нь Газрын тухай хуулийн зарим заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- “Ачит Ихт” ХХК-тай 2011 оны 7 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан 01 дугаар “Газар ашиглах тухай” гэрээнд³¹, үйлдвэрлэл явуулах хугацаанд нийт 28.96 га газрыг³² ашиглуулахаар тусгасан нь Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “...Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээдэд газар ашиглуулах” гэж заасантай нийцээгүй,
- “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 5/346-14 дугаар “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх” гэрээнд³³...үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж, хүхрийн хүчлийн агуулах барих үйл ажиллагаа явуулахад нийт 60.5 га газрыг эзэмшүүлэхээр тусгасан нь Газрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т “Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь...” гэсэн нөхцөлийг хангаагүй,
- “ДэБЭТэ” ХХК-тай 2015 оны 08 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан 5/239-15 дугаар “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” гэрээнд³⁴...баяжуулах фабрикийн хаягдлаас зэс, молибденийг ялгах үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж барих үйл ажиллагааг явуулахад нийт 7.727 га газрыг эзэмшүүлэхээр тусгасан нь Газрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т “Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь...” гэсэн нөхцөлийг хангаагүй, гэрээний 1.4-т “энэхүү гэрээний хугацаа талуудын хооронд байгуулсан 2012 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн №5/251-12 дугаар Хамтран ажиллах гэрээний 1.2-т уг гэрээгээр “Компани”-д 30 жилийн хугацаагаар олгосон хугацаагаар тогтооно” гэж заасан нь Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 169 дугаар захирамжаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д нийт 11,353.71 га газрыг 20 жилийн хугацаатай ашиглуулах шийдвэртэй зөрчилдөж байна.

2.20. “Зэс-Эрдэнийн хувь” ХХК-тай 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх” 5/346-14 дугаар гэрээний 1.5-д “энэхүү гэрээний хугацаа нь хайгуулын XV-002606 дугаар тусгай зөвшөөрлийн хуулиар олгогдсон хүчин төгөлдөр хугацаанд үйлчилнэ” гэж заасан тул “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшиж байсан хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр дуусгавар болсноор тус гэрээг хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлгүй байна.

2.21. “Ачит Ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт Эксплорейшн” ХХК-д олгосон газрын хэмжээ заагийг тэмдэгжүүлэх, координатжуулах, кадастрын зургийг гаргахдаа Орхон аймгийн Газрын албатай зөвшилцөхгүйгээр³⁵ үйлдсэн байна.

Гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна

2.22. “Ачит Ихт” ХХК, “Зэс-Эрдэнийн хувь” ХХК, “Морьт Эксплорейшн” ХХК-тай байгуулсан гэрээний зарим заалтууд хэрэгжээгүй, талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээний үр дүнг тооцоогүй байна.

³⁰ Газрын тухай хуулийн 23.3.7. Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох;

³¹ 2010.09.04-ны өдрийн 5/255-10 дугаар Хамтран ажиллах тухай гэрээний 2.1.1...Балансын гадуурх овоолгоос зэс гаргаж авах төхөөрөмжийг суурилуулах талбай гаргах өгөх... заалтыг үндэслэн

³² үндсэн үйлдвэрлэлийн барилга, байгууламжид зориулж 9.2 га, 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамын аюулгүйн бүсийн 18,9 га, салаа төмөр зам бүхий хүхрийн хүчлийн агуулахын барилгад 0,86 га талбай

³³ Талуудын хооронд 2013.05.02-ны өдөр байгуулсан 05/096-13 тоот Хамтран ажиллах гэрээг үндэслэн,

³⁴ Талуудын хооронд 2012.07.18-ны өдрийн №5/251-12 тоот болон 2014.04.21-ний өдрийн №5/145-14 тоот Хамтран ажиллах гэрээг үндэслэн

³⁵ 23.4.3. эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх;



2.23. Аудитын явцад “Орхон аймгийн Гаалийн газраас “Ачит Ихт” ХХК-ийн 2014-2017 оны гаалийн бүрдүүлэлт, экспортод гаргасан барааны тоо хэмжээ, статистик дүнг авч, тооцоолж үзэхэд нийт 408,826.0 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүү гарч байгаа нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК ашиглалтын төлбөрийн тооцооллыг тухай бүрд нь хянаж, баталгаажуулаагүйгээс дээрх дүнгээр орлого олох боломжийг алдсан тул “Ачит Ихт” ХХК-тай байгуулсан гэрээний 2.6, 3.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. *(Хавсралт № 4)*

Хүснэгт № 7

“Ачит Ихт” ХХК-ийн экспортод гаргасан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын орлогын дүнд суурилан тооцсон ашиглалтын төлбөрийн тооцоолол

(төгрөгөөр)

	хамрагдах хугацаа	Ашиглалтын төлбөр/ НӨАТ-гүй/	НӨАТ	Ашиглалтын төлбөр/ НӨАТ-тэй/
"Эрдэнэт үйлдвэр" ХХК-д хүлээн авсан ашиглалтын төлбөр	2015 оны нийт дүн 0.5%	498,454,030.58	49,845,403.05	548,299,433.63
	2016 оны нийт дүн 1%	1,277,099,957.75	127,709,995.78	1,404,809,953.53
	2017 оны 3 улирлын нийт дүн 1.5%	2,003,558,158.95	200,355,815.89	2,203,913,974.84
	2015-2017 оны 3 улирал нийт дүн	3,779,112,147.28	377,911,214.72	4,157,023,362.00
Аудитаар тооцсон	2015 оны нийт дүн 0.5%	512,613,124.87	51,261,312.49	563,874,437.36
	2016 оны нийт дүн 1%	1,412,991,631.97	141,299,163.20	1,554,290,795.17
	2017 оны 3 улирлын нийт дүн 1.5%	2,225,167,390.92	222,516,739.09	2,447,684,130.01
	2015-2017 оны 3 улирал нийт дүн	4,150,772,147.76	415,077,214.78	4,565,849,362.54
зөрүү дүн	2015 оны нийт дүн 0.5%	14,159,094.29	1,415,909.44	15,575,003.73
	2016 оны нийт дүн 1%	135,891,674.22	13,589,167.42	149,480,841.64
	2017 оны 3 улирлын нийт дүн 1.5%	221,609,231.97	22,160,923.20	243,770,155.17
	2015-2017 оны 3 улирал нийт дүн	371,660,000.48	37,166,000.06	408,826,000.54

Эх сурвалж: Орхон аймгийн Гаалийн газраас ирүүлсэн судалгаа

2.24. “Ачит Ихт” ХХК, “Зэс Эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-иудтай байгуулсан гэрээний гол заалтууд хэрэгжээгүй, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас гэрээний үүргийн биелэлт, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, үр дүнг тооцоогүй байна.

Хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэрээнд заасан нөхцөлийн дагуу үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй байна

2.25. “Ачит Ихт” ХХК 2015 оны 5/199-15 дугаар гэрээний 2.2 дахь заалтыг үндэслэн 2015 онд 449,964.6 мянган төгрөг, 2016 онд 998,731.6 мянган төгрөг, 2017 онд 2,708,327.2 мянган төгрөг, нийт 4,157,023.3 мянган төгрөгийн ашиглалтын төлбөрт төлсөн байна. *(Хавсралт № 5)*

2.26. “Ачит Ихт” ХХК“ 2015 онд борлуулсан катодын зэсийн тоо хэмжээ, 2017 оны 1-6 сарын ашиглалтын төлбөрийн тооцооллыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д ирүүлээгүй байна.

2.27. Аудитын явцад “Ачит Ихт” ХХК-ийн 2014 оны 11 дүгээр сараас 2017 оны 9 дүгээр сарын хүртэлх гаалийн статистик мэдээ дэх экспортод гаргасан 36,350.5 тн катодын зэс, 408,785,042.9 мянган төгрөгийн борлуулалтын орлогын дүнд тулгуурлан ашиглалтын төлбөрийг гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцоход нийт 4,657,252.5 мянган төгрөгийг “Ачит Ихт” ХХК-иас “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д төлөх тооцоо гарч байна.



“Ачит ихт” ХХК-ийн гаалийн бүрдүүлэлтийн тоо мэдээнд үндэслэсэн тооцсон борлуулалтын орлого, ашиглалтын төлбөрийн судалгаа

(сая төгрөгөөр)

огноо	катодын зэс хэмжээ /тн/	борлуулалтын орлого	ногдуулах хувь	Ашиглалтын төлбөр /НӨАТ- гүй/	НӨАТ	Аудитаар тооцсон ашиглалтын төлбөр /НӨАТ-тай/	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-д төлсөн дүн	зөрүү
А	1	2	3	4=(2*3)/100	5=4*10/100	7=4+5	8	9=7-8
2014 он	1,402.2	16,618.8	0.5	83.1	8.3	91.4	0.0	91.4
2015 он	10,530.2	102,522.6	0.5	512.6	51.3	563.9	548.3	15.6
2016 он	13,810.3	141,299.2	1.0	1,413.0	141.3	1,554.3	1,404.8	149.5
2017 оны 3 улирал	10,607.8	148,344.5	1.5	2,225.2	222.5	2,447.7	2,203.9	243.8
Нийт дүн	36,350.5	408,785.0		4,233.9	423.4	4,657.3	4,157.0	500.2

Эх сурвалж: Орхон аймгийн Гаалийн газраас ирүүлсэн судалгаа

2.28. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь “Ачит Ихт” ХХК-ийн борлуулсан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын дүнг валютын ханштай уялдуулан ашиглалтын төлбөрийг зөв ногдуулсан эсэхийг хянадаггүй, ашиглалтын төлбөрийг нэмэгдсэн өртгийн албан татвар тооцоогүй дүнгээр хүлээн авснаас шалтгаалан “Ачит Ихт” ХХК /НӨАТ төлөгчийн 2011 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 46102 дугаар гэрчилгээ эзэмшигч/-ийн ашиглалтын төлбөрийг 2015-2017 онд 408.8 сая төгрөгийг дутуу тооцсон зөрчил илэрсэн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.29. “Ачит Ихт” ХХК-тай байгуулсан “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” гэрээнд заасан газрын төлбөрийг хууль, журмын дагуу бүрэн тооцож аваагүй, “Газар ашиглах тухай” гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлээгүйгээс “Эрдэнэт үйлдвэр” ХХК газрын төлбөрт 66,812.2 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Үүнд:

“Ачит Ихт” ХХК-тай байгуулсан гэрээ:

- “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 5/199-14 дугаар гэрээний 1.4-т заасны дагуу /2014.05.19-ний өдрөөс 2014.09.14-ний өдөр хүртэл 115 хоногт ногдох төлбөрийг 549.2 ам.доллар буюу 1,012.8 мянга/, 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан 5/33014 дугаар гэрээний 1.5-т заасны дагуу /2014.09.15-ны өдрөөс 2015.01.22-ны өдөр хүртэл 126 хоногт ногдох төлбөрийг 585.6 ам.доллар буюу 1,169.9 мянга/ Ашигт малтмалын тухай хуулийн 32.3-т “...уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар...” дагуу тооцохдоо нийт 1,120.2 ам.доллар буюу 2,182.7 мянган төгрөг тооцож авахаас 1,394.7 мянган төгрөгөөр дутуу, эдэлбэр газартай давхцаж буй 40.96 гектар газрын төлбөрийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын дагуу тооцохдоо нийт 32,453.8 мянган төгрөгөөр тооцож авахаас 2,416.4 мянган төгрөгөөр дутуу, мөн 2014 оны газрын төлбөрийг тухайн онд нь тооцож аваагүйгээс 6,187.0 мянган төгрөгийг аваагүй, газрын төлбөрийг нийт 9,998.2 мянган төгрөгөөр дутуу тооцсон зөрчил илэрсэн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.
- “Газар ашиглах тухай” 2011 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар гэрээний 2.2-т “Ачит Ихт” ХХК-ийн ашиглах талбайн газар ашиглалтын төлбөрийг хоёр тал тусгай гэрээгээр зохицуулна” гэж заасан боловч гэрээ үйлчлэх хугацаанд тусгай гэрээ байгуулаагүйгээс “Ачит Ихт” ХХК-ийн ашиглаж байгаа 28.96 га газарт 2011 оны 07 дугаар сарын 15-наас 2014 оны 01 дүгээр сарын 16 хүртэлх 2 жил 10 сарын хугацаанд газрын төлбөрт “Эрдэнэт үйлдвэр” ХХК нийт 49,232.0 мянган төгрөгийг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна. (Хавсралт № 7)

2.30. “Эрдмин” ХХК-д “Хүдэр нийлүүлэх” гэрээний дагуу 2001-2011 онд нийт 17,593.6 мянган тн /исэлдсэн хүдэр 14,793.6 мянган тн, балансын бус хүдэр 2,800.0 мянган тн/ исэлдсэн болон балансын бус хүдрийг 6,023,311.6 мянган төгрөгөөр нийлүүлсэн байна.

2.31. “Эрдмин” ХХК 2004-2017 онд 92,700.0 мянган ам.долларын ногдол ашиг тооцоноос “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д тухай бүрд нь 25 хувиар тооцож, нийт 23,175.0 мянган ам.долларын ногдол ашгийг хуваарилсан нь тус үйлдвэрт оруулсан 2,500.0 мянган ам долларын хөрөнгө оруулалтыг 10 жилийн хугацаанд 9.3 дахин өсгөж авчээ. (Хавсралт № 6)

2.32. “Ачит Ихт” ХХК-тай байгуулсан 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан АИ-13/02 дугаар гэрээний 2.2-т “А” тал компанийн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахад шаардлагатай балансын бус хүдэр өгч байгааг үндэслэн “Ачит Ихт” ХХК-ийн хувь хөрөнгийн 34 хувийг эзэмшинэ... гэж заасны дагуу “Ачит Ихт” ХХК-ийн 2014-2016 он болон 2017 оны 2 дугаар улирлын цэвэр ашгаас гэрээнд заасан 34 хувиар ногдол ашиг олгохоор тооцоолж үзэхэд 3 жил 6 сарын хугацаанд нийт 61,727,726.1 мянган төгрөгийн үр өгөөжийг хүртэх боломжтой байжээ.



2.33. ТӨХ-ноос 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 1а/3777 дугаар албан бичгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Даваацэрэнд “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Эрдмин” ХХК-тай хэрхэн хамтран ажиллах, балансын болон балансын бус хүдрийн овоолгыг хэрхэн оновчтой үр өгөөжтэй ашиглах, үүнтэй холбогдуулан авах арга хэмжээний талаарх саналаа ирүүлэх чиглэл өгч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн удирдлага 2014 оны ЦД-117-12/45 дугаар албан бичгээр “ТӨХ-ны дарга, ”Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн Монголын хэсгийн даргад дээрх компаниудын талаар баримтлаж буй үндсэн зарчим, саналыг хүргүүлсэн боловч, тус саналд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хүртэх үр ашиг, үр өгөөжийн талаар тодорхой санал тусгаагүй байна.

Хүснэгт № 9

**“Ачит Ихт” ХХК-ийн төлбөл зохих
ногдол ашгийн судалгаа**

(төгрөгөөр)

огноо	цэвэр ашиг /төгрөг/	Тооцоолсон хувь	Тооцоолсон дүн
2014	14,739,434,500.0	34%	5,011,407,730.0
2015	53,627,594,500.0	34%	18,233,382,130.0
2016	65,009,070,300.0	34%	22,103,083,902.0
2017 оны 2 улирал	48,176,036,200.0	34%	16,379,852,308.0
Нийт дүн	133,376,099,300.0		61,727,726,070.0

Эх сурвалж: “Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл



БҮЛЭГ 3. Бүтээгдэхүүн борлуулах гэрээний нөхцөлд тохирсон зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх зардлыг үндэслэлгүй тогтоож, охин болон хараат компаниудад үр ашиггүй хөрөнгө оруулалт хийсэн байна

Бүтээгдэхүүн борлуулах гэрээний нөхцөлд тохирсон зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх зардлыг үндэслэлгүй тогтоосон байна

3.1. Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1³⁶, 88 дугаар зүйлийн 88.1³⁷, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2007 онд батлагдсан Дүрмийн 11.6.8³⁸, 11.7³⁹, 2016 онд батлагдсан Дүрмийн 9.17.16⁴⁰-д их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ (Зөвлөл) олгохоор заасныг зөрчин “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал болон түүний орлогч, Худалдааны хэлтсийн дарга нар их хэмжээний хэлцэл хийж, 2015-2017 онд нэр бүхий 13 компанитай борлуулалтын гэрээг байгуулсан байна. (Хүснэгт № 12-оос компаниудийн нэрийг харна уу)

3.2. Энэ нь борлуулалтын гэрээг хяналтгүйгээр байгуулах, зэс болон молибдений баяжмалын олон улсын зах зээлийн үнээс хасагдах зардлуудыг өндөр тогтоох эрсдэлийг үүсгэж байна.

3.3. Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4⁴¹, үйлдвэрийн Дүрмийн 2.3.10⁴²-т заасны дагуу олон улсын зах зээлийн үнийг үндэслэн борлуулалтын үнээ компани өөрөө тогтоож байна.

3.4. “Эрдэнэт үйлдвэр” ХХК зэсийн баяжмалын борлуулалтын үнийг тогтоохдоо “Лондонгийн металлын бирж”-ээс зарласан ханшийг суурь болгож, хараат бус, хөндлөнгийн лабораториор тогтоосон 1 тонн зэсийн баяжмал дахь зэсийн эцсийн агууламжийн хувиас хайлуулах үеийн хорогдол 1.1 хувь, зэс хайлуулах болон цэвэршүүлэх зардал, мөнгө цэвэршүүлэх зардал, хорт бодис арсеникийн төлбөрийг тус тус хасч, тогтоодог байна.

3.5. Тус үйлдвэр молибдений баяжмалын үнийг тогтоохдоо “Platt’s Metals Daily” сэтгүүлд хэвлэгдсэн молибдений техникийн ислийн дундаж үнийг 0.72 коэффициентээр үржүүлж, тооцсон байна.

Хүснэгт № 10

Борлуулсан зэс болон молибдений баяжмалын тоо хэмжээ, үнийн судалгаа

(ам.доллар)

Огноо	Бүтээгдэхүүний нэр	Хуурай жин /мян тн/	металл /мян тн/	Борлуулсан дундаж үнэ	Олон улсын дундаж үнэ	Үнийн зөрүү	Нийт үнэ (сая ам.дол)
1	2	3	4	5	6	7	8=(4*5)
2015/12/31	Зэсийн баяжмал	543.4	126.9	4,055.4	5,501.7	1,446.3	514.6
2016/12/31	Зэсийн баяжмал	600.5	139.6	3,899.9	4,871.6	971	544.4
2017/09/30	Зэсийн баяжмал	443.6	103.6	5,039.0	6,032.7	993	522.0
2015/12/31	Молибдений баяжмал	5.0	2.5	10,043.0	14,665.1	4,622.1	25.1
2016/12/31	Молибдений баяжмал	5.3	2.6	10,326.7	14,294.8	3,968.1	26.8
2017/09/30	Молибдений баяжмал	4.5	2.3	12,734.8	17,753.8	5,019.0	29.2

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015, 2016 он болон 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан

3.6. “Эрдэнэт үйлдвэр” ХХК зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх зардалд олон улсын зах зээлийн ханшаар тооцсон борлуулалтын нийт үнээс дунджаар 2015 онд 26.3 хувь буюу 183.6 сая ам.доллар, 2016 онд 19.9 хувь буюу 135.6 сая ам.доллар, 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 16.5 хувь буюу 102.9 сая ам.долларыг борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хасч тооцсон байна.

³⁶ хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/.

³⁷ Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргана.

³⁸ Их хэмжээний хэлцлийн шалгуурыг Монголын хууль тогтоомжийн дагуу тогтоож энэ төрлийн хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох.

³⁹ Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар их хэмжээний хэлцэл болон сонирхолын зөрчил бүхий хэлцлийг батлах.

⁴⁰ Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

⁴¹ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий хуулийн этгээд ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах.

⁴² Аж ахуйн үйл ажиллагаагаа төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гүйцэтгэх ажил, үйлчилгээнийхээ хэмжээ, өөрийн өртгийг тодорхойлох, түүнчлэн борлуулалтын үнээ өөрөө тогтоох.



3.7. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн зэсийн баяжмалын борлуулалтын гэрээний нөхцөлд тохирсон хайлуулах болон цэвэршүүлэх зардлын хэмжээ reuters.com, metalbulletin.com сайтад нийтлэгдсэн CSPT /China Smelters Purchase Team/ буюу Хятадын хайлуулах үйлдвэрүүдийн худалдан авах багийн улирал бүр гаргасан үнээс 10.5-35.0 хувиар өндөр байна.

3.8. Зэсийн баяжмалын борлуулалтын гэрээний нөхцөлд тохирсон хайлуулах зардлын хэмжээг Хятадын хайлуулах үйлдвэрүүдийн худалдан авах багийн улирал бүр гаргасан үнээс өндөр тогтоосноор 2015 онд 31.5 сая ам.доллар, 2016 онд 8.4 сая ам.доллар, 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 5.3 сая ам.долларыг хэмнэх боломжийг алдсан байна.

Хүснэгт № 11

Зэсийн баяжмалыг хайлуулах болон цэвэршүүлэх зардлын харьцуулсан судалгаа

Д/д	Огноо	Борлуулсан зэсийн баяжмалын хэмжээ /Хуурай метр тонн/	Борлуулалтын гэрээнд нэг хуурай тонн зэсийн баяжмал		Reuters.com, Metalbulletin.com сайтад мэдээлсэн үнэ		Зөрүү	
			Хайлуулах зардал /ам.доллар/	Цэвэршүүлэх зардал /цент/ LB	Хайлуулах зардал /ам.доллар/	Цэвэршүүлэх зардал /цент/ LB	Хайлуулах зардал /сая ам.доллар/ (3-5) *2	Цэвэршүүлэх зардал /мян ам.доллар/ LB (4-6) *2
1	2015	543,407.8	165.0	16.5	107.0	10.7	31.5	31.5
2	2016	600,503.8	120.0	12.0	106.0	10.6	8.4	8.4
3	2017/9	443,645.6	114.0	11.4	102.0	10.2	5.3	5.3

Эх сурвалж: Аудитын судалгаа, тооцоолол

3.9. “Эрдэнэт үйлдвэр” ХХК молибдений баяжмалын борлуулалтын үнийг тогтоохдоо “Platt’s Metals Daily” сэтгүүлд хэвлэгдсэн молибдений техникийн ислийн дундаж ханшаар тооцсон борлуулалтын нийт үнээс 2015 онд 30.8 хувь буюу 11.2 сая ам.доллар, 2016 онд 28.7 хувь буюу 10.8 сая ам.доллар, 2017 онд 27.7 хувь буюу 11.2 сая долларыг тооцоо, судалгаанд үндэслэхгүй шууд хасч тооцсон байна.

Борлуулалтын гэрээний дагуу бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй байна

3.10. “Эрдэнэт үйлдвэр” ХХК экспортолж буй зэсийн баяжмал борлуулах гэрээг дэлхийд нэр хүнд бүхий 13 худалдааны компанитай байгуулж, 2015 онд 678.7 мянган тонн зэсийн баяжмал нийлүүлэхээс 595.0 мянган тонн, 2016 онд 838.5 мянган тонн зэсийн баяжмал нийлүүлэхээс 657.3 мянган тонн, 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 454.4 мянган тонн зэсийн баяжмал нийлүүлэхээс 486.1 мянган тонныг тус тус нийлүүлсэн байна.

Хүснэгт № 12

Борлуулалтын гэрээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Д/д	Компанийн нэр	2015			2016			2017 оны 9-р сар		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
1	Gerald Metals	-	-	-	40.0	35.6	(4.4)	34.1	37.3	3.2
2	Red Metal	-	-	-	120.0	75.7	(44.3)	39.0	64.7	25.7
3	Cliveden Trading	-	-	-	3.0	2.9	(0.1)	12.3	12.2	(0.1)
4	Ocean Partners	120.0	102.0	(18.0)	120.0	115.9	(4.1)	90.0	89.9	(0.1)
5	Samsung C&T	90.0	89.9	(0.1)	90.0	89.6	(0.4)	83.4	78.0	5.4
6	Nipro Management	30.0	23.5	(6.5)	25.5	26.8	1.3	-	0.5	0.5
7	Trafigura PTE	84.0	73.6	(10.4)	100.0	105.9	5.9	62.0	67.3	5.3
8	Milliford Global	110.0	110.0	0	110.0	115.6	5.6	56.0	66.9	10.9
9	Taurus Metals	74.7	70.7	(4)	80.0	78.0	(2)	47.6	52.4	4.8
10	CWT Commodities	70.0	55.2	(14.8)	-	6.3	6.3	-	-	-
11	Mineral Group	100.0	70.1	29.9	150.0	5.0	145.0	-	-	-
12	Kanetic PTE	-	-	-	-	-	-	25.2	-	(25.2)
13	Clearedge Trading	-	-	-	-	-	-	4.8	17.0	12.2

Эх сурвалж: Борлуулалтын гэрээ

3.11. Зэсийн баяжмал худалдан авагч компани гэрээнд заасан хугацаанд ачилт явуулах хаягаа ирүүлээгүй, төлбөрөө шилжүүлээгүй, төлбөрийг төлсөн боловч ачилтыг хүлээн авах тухай мэдэгдлээ ирүүлээгүй, төлбөрийн чадваргүй болсон, зэсийн баяжмал хүлээн авагч үйлдвэрт гарсан засварын ажил бусад хүндрэлээс шалтгаалан “Эрдэнэт үйлдвэр” ХХК гэрээнд заасан хуваарийн дагуу ачилтыг хийгээгүй, хүчинтэй хугацаа нь дууссан зарим гэрээний үлдэгдлийг дараа онд нь ачсан зэрэг нөхцөл байдал үүссэн байна.

**Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт үр ашиггүй байна**

3.12. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлийн 2007 оны 38 дугаар хуралдаанаар баталсан үйлдвэрийн Дүрмийн 11.6.12-т “Охин компани байгуулах, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, Монгол Улс болон гадаадад байгаа хувьцаат компани болон аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах асуудлаар компанийн гүйцэтгэх удирдлагаас гаргасан холбогдох шийдвэрийг батлах” гэж заажээ.

3.13. Үйлдвэрийн Дүрмийн 11.6.12-т заасны дагуу охин болон хараат компани байгуулах гүйцэтгэх удирдлагын шийдвэрийг Зөвлөл батлаагүй байгаа нь үр ашиггүй хөрөнгө оруулалт хийх үр дагаврыг үүсгэсэн байна.

Хүснэгт № 13

Охин болон хараат компанийн ерөнхий мэдээлэлийн судалгаа

Компанийн нэр	Компанийн статус	Байгуулагдсан огноо	Дүрмийн сан	Эзэмшлийн хувь	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн		Хуваарилсан ногдол ашиг
					Өглөг (төгрөг)	Авлага (төгрөгөөр)	
“Эрдсүлж” ХХК	Охин	2006.10.06	1,170,844,334.0 ₮	100	-	-	Байхгүй
“РСЦ” ХХК	Охин	2006.10.06	5,700,314,228.0 ₮	100	3,576,010,108.0	-	1,255,796,102.0 ₮
“Шим технолоджи” ХХК	Хараат	2003.09.06	8,382,039,900.0 ₮	30	-	21,710,022,477.4	Байхгүй
“Эрдэнэт-Ойл” ХХК	Хараат	2008.12.15	100,000.0 \$	50	10,325,602.6	-	102,000,000.0 ₮
“Эрдмин” ХХК	Хараат	1994.03.14	10,000,000.0 \$	25	-	-	23,925,000.0 \$

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015, 2016 он болон 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан

3.14. “Шим технолоджи” ХХК-ийн Дүрмийн 4.2-т заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК энгийн хувьцааны 30 хувийг эзэмшиж, 2,514,611,700.0 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийх ёстой. Гэвч дүрэмд заагдсан хөрөнгө оруулалтын дүнгээс 24,111,056.00 төгрөгийг илүү оруулсан нь эзэмшиж буй энгийн хувьцааны дүн бодис бус илэрхийлэгдэх үр нөлөөтэй байна.

Хүснэгт № 14

“Шим технолоджи” ХХК-ийн өрийн судалгаа

Гэрээний дугаар	Төлөгдөөгүй мөнгөн дүн /ам.доллар/	Долларын ханш	Өр төлбөрийн дүн /төгрөгөөр/
A	I	2	3=I*2
E-2004/01-МО	2,451,705.79	2,464.43	6,042,057,300.05
E-2014/01-МО	1,454,049.36	2,464.43	3,583,402,864.27
E-2015/01-МО	4,510,075.36	2,464.43	11,114,765,019.45
E-2016/01-МО	336,481.82	2,464.43	829,235,842.37
E-2017/03-МО	57,036.07	2,464.43	140,561,401.99
Нийт дүн	8,809,348.4	2,464.43	21,710,022,477.41

Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2015, 2016 он болон 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан

3.15. “Эрдэнэт үйлдвэр” ХХК гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байхад удаа дараа “Шим технолоджи” ХХК-тай молибдений баяжмал нийлүүлэх гэрээг байгуулж 21.7 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.16. “Шим технолоджи” ХХК борлуулалтын гэрээний 9.2⁴³, 9.4⁴⁴ дэх заалтыг зөрчин “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас худалдан авсан молибдений баяжмалын төлбөрийг бүрэн шилжүүлэхгүй өр үүсгэж байхад дахин гэрээ

байгуулж, баяжмал нийлүүлэн өрийн хэмжээг нэмэгдүүлж байгаа нь гэрээ байгуулах эрх бүхий этгээдэд ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна.

3.17. “Эрдэнэт-Ойл” ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь өндөр чанарын тос, тосолгооны материал үйлдвэрлэх, бүтээгдэхүүнээ дотоод болон гадаадын зах зээлд нийлүүлэх бөгөөд тус компанийн энгийн хувьцааны 50 хувийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК эзэмшиж байна. Гэвч “Эрдэнэт-Ойл” ХХК-ийн байршил, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа нь галын аюулгүйн норм, дүрмийг ноцтой зөрчсөн, чанарын шаардлага хангахгүй, зөвхөн ОХУ-д үйлдвэрлэсэн машин техник, тоног төхөөрөмжид хэрэглэгдэх боломжтой тос, тосолгооны материалыг үйлдвэрлэж байгаа нь тус компанийн Дүрмийн 5⁴⁵ дугаар зүйлийг зөрчсөн байна.

⁴³ Худалдан авагч нь Худалдагчийн нэхэмжилсэн урьдчилгаа төлбөрийг урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэх гарсан өдрөөс хойш банкны 5 өдөрт багтаан цахим шилжүүлгээр 100% шилжүүлэх үүрэгтэй.

⁴⁴ Талуудын хоорондох эцсийн тооцоо нь баяжмалын лот тус бүрийн химийн шинжилгээний хариуг хүлээн авснаас хойш банкны 5 хоногийн дотор гэрээний 11-р зүйлд зааснаар 7 болон 8-р зүйлийг мөрдлөг болгон тооцсон Худалдагчийн эцсийн тооцооны нэхэмжлэхийн дагуу гүйцэтгэгдэнэ.

⁴⁵ Өндөр чанарын тос тосолгооны материал үйлдвэрлэх



3.18. “Эрдэнэт-Ойл” ХХК нь 2010 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй зогссон нь тус компанид оруулсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болох эрсдэлийг дагуулж байна.

3.19. “Эрдсүлж” ХХК нь ажлын хувцасны үйлдвэр бөгөөд 2006 онд байгуулагдсанаас хойш бараг ашиггүй ажиллаж “Эрдэнэт үйлдвэр” ХХК-нд ногдол ашиг хуваарилаагүй байна. Ашиггүй ажиллаж байгаа нь ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл нийт зардлын 48.8-53.7 хувийг эзэлж, 2016 оны 7 дугаар сард “Өсөх зууч” ХХК, “Бум Оюу” ХХК, “Глобал аккуант” ХХК, “Наран жигүүр” ХХК, “Мон петро” ХХК, “Талст хаш” ХХК зэрэг зургаан компаниас 164.0 сая төгрөгийн түүхий эд, материалыг зах зээлийн үнээс харьцангуй өндөр үнээр шууд худалдан авалт хийсэн нь нөлөөлсөн байна.

Гүйцэтгэх удирдлага 6.6 тэрбум төгрөгийг холбогдох хууль, журмыг зөрчин үр ашиггүй зарцуулжээ.

3.20. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нийт зардлыг 2015 онд 94.1 тэрбум төгрөгөөр хэмнэж, 2016 онд 13.0 тэрбум төгрөгөөр, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 45.2 тэрбум төгрөгөөр тус тус хэтрүүлж, нийт зардал 2016 онд өмнөх оноос 159.3 тэрбум төгрөгөөр буюу 13.4 хувиар өссөн байна.

3.21. Дунджаар нийт зардлын 57.1 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 23.8 хувийг үйл ажиллагааны зардал, 5.2 хувийг нийгмийн цехүүдийн зардал, 5.1 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 7.0 хувийг бусад зардал, 1.6 хувийг зээлийн хүүгийн зардал, 0.2 хувийг бусад борлуулалтын өртөг, 0.1 хувийг нийтийн хоолны хэсгийн зардал тус тус эзэлж байна.

3.22. 2017 оны 3 дугаар улирлын байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 13.4 пунктээр, нийгмийн цехүүдийн зардлыг 2.4 пунктээр бууруулсан боловч үйл ажиллагааны зардлыг 8.2 пунктээр, ерөнхий ба удирдлагын зардлыг 7.8 пунктээр, бусад зардлыг 1.4 пунктээр тус тус нэмэгдүүлсэн байна.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр иргэн, аж ахуйн нэгжид 49.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, 1.7 тэрбум төгрөгийн хандив өгсөн байна

3.23. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын тушаалаар 2015 онд 307.5 сая төгрөгийн, 2016 онд 1,116.7 сая төгрөгийн, 2017 оны 3-р улирлын байдлаар 259.6 сая төгрөгийн, нийт 1,683.8 сая төгрөгийн хандив, тусламжийг иргэн, аж ахуйн нэгжид өгсөн байна. Үүнээс Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын тушаалыг үндэслэн нийт 198.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй шилжүүлж, хандивласан байна.

3.24. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

3.25. Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2015 онд 292.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 82.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, 2016 онд 50,242.9 сая төгрөгийн анхны өртөгтэй 50,242.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, 2017 онд 416.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 196.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, нийт 50,951.8 сая төгрөгийн анхны өртөгтэй 49,844.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг байгууллага, хувь хүнд үйлдвэрийн Ерөнхий захирлын тушаалыг үндэслэн шилжүүлсэн байна.

3.26. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30-р зүйлийн 1-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, 2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн



захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.” гэж заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

Үйлдвэрийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж иржээ

3.27. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2012 оны 12 дугаар сард 5/017-13 дугаар “Орон сууц барих тухай гэрээ”-г “Ижилманлай” ХХК-тай байгуулж, гэрээнд заасны дагуу дараах гүйлгээгээр 2 орон сууцны үнийг төлжээ. Үүнд:

- 2013 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 246 дугаар төлбөрийн даалгавараар 100.0 сая төгрөг,
- 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 354 дүгээр төлбөрийн даалгавараар 100.0 сая төгрөг,
- 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 533 дугаар төлбөрийн даалгавараар 243.5 сая төгрөг,
- 2013 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 1799 дүгээр төлбөрийн даалгавараар 166.3 сая төгрөг, нийт 609.8 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

3.28. “Ижилманлай” ХХК-ийн нэхэмжлэл болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 2013 оны 2,3 дугаар сард шилжүүлсэн төлбөрийн даалгавар дээр зурагдсан 1 дүгээр гарын үсэг 1 хүнийх байх магадлалтай байгаа тул холбогдох байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байна.

3.29. “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2013 оны 6 дугаар сард “Ижилманлай” ХХК-ийн барьсан 5 дугаар байрны 5 өрөө бүхий 502 тоот орон сууцыг 1 жилийн хугацаатай ⁴⁶ түрээслэхээр иргэн Д.Дуламсүрэнгэй 5/001-14 дугаар гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Үүнд:

2014 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр:

- гэрээний хугацааг 2 жилийн хугацаатай сунгасан;
- 502 тоот орон сууцны түрээсийн төлбөрийг сарын 1200 ам.доллар болгосон;
- 201, 501 тоот орон сууцны хэрэглээний зардлыг сарын 800 ам.доллар болгосон.

2016 оны 06 дугаар сарын 25-ны өдөр дахин нэмэлт⁴⁷ өөрчлөлтөөр:

- Гэрээний хугацааг 2 жилээр сунгасан.

3.30. Гэрээг үндэслэн иргэн Д.Дуламсүрэнгийн хувийн харилцах дансанд дараах түрээсийн болон хэрэглээний зардалд нийт 83.9 сая төгрөг, 14400 ам.долларыг шилжүүлжээ. Тодруулбал:

- 2013 оны сүүлийн хагас жилийн түрээсийн төлбөрт 2014 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр төлбөрийн даалгавараар 16.4 сая төгрөг,
- 2014 оны эхний хагас жилийн түрээсийн төлбөрийн 2014 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 110 дугаар төлбөрийн даалгавараар 16.4 сая төгрөг,
- 2014 онд гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэн 2014 оны сүүлийн хагас жилийн түрээс, хэрэглээний зардалд 2014 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 649 дүгээр төлбөрийн даалгавараар 21.9 сая төгрөг,
- 2015 он⁴⁸д 14.1 сая төгрөг, 7200 ам.доллар,
- 2016 онд 7200 ам.доллар, 15.1 сая төгрөг.

3.31. Үйлдвэр өөрийн өмчлөлийн 201, 501, 502 тоот орон сууцны хэрэглээний зардлыг “Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-тай гэрээ байгуулан төлсөн бол жилд нийт 6.6 сая төгрөг, 2014-2016 онд 501 тоотод 4.4 сая төгрөг, 201 тоотод 5.1 сая төгрөг /2014-2016 он хүртэл/, 502 тоотод 1.9 сая төгрөг, нийт 11.4 сая төгрөгийг хэрэглээний зардалд төлөхөөр тооцоо гарч байна.

Хүснэгт № 15
201,501,502 тоот орон сууцны хэрэглээний зардлын тооцоо

Орон сууцны дугаар	Сард төлөх дүн	Жилд төлөх дүн
		(мянган төгрөгөөр)
502	160.1	1,921.2
501	185.2	2,222.4
201	211.7	2,540.4
Нийт дүн	557.0	6,684.0

Эх сурвалж: Аудитын судалгаа, тооцоолол

3.32. Зах зээлийн ханшнаас хэт өндөр үнээр орон сууц түрээслэх, орон сууцны хэрэглээний зардлыг ам.доллараар төлөх гэрээг байгуулж, 2014-2015 онд 104.8 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагатай байна.

⁴⁶ орон сууцны түрээсийн төлбөрт сарын 1100 ам.доллар, худалдаж авсан 2 орон сууц буюу 201, 501 тоотын хэрэглээний зардалд сарын 500 ам.доллар, нийт сарын 1600 ам.доллар төлнө.

⁴⁷ 201, 501, 502 тоот орон сууцны хэрэглээний зардалд сарын 1200 ам.доллар төлнө.

⁴⁸ “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн түрээсээр ашиглаж байгаа 502 тоот орон сууцыг 2014 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр 173000 ам.доллаароор худалдаж авахаар⁴⁸ Ижил манлай ХХК-тай “Худалдах худалдан авах гэрээ”-г байгуулсан.



3.33. Хөдөлмөрийн гэрээг үндэслэн “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгагдаагүй эмчилгээний зардал, сургалтын төлбөр, ажлаас чөлөөгдсөний тэтгэмж болгон 2015 онд 13 хүнд 610.5 сая төгрөг, 2016 онд 18 хүнд 3,856.6 сая төгрөг, 2017 онд 2 хүнд 196.7 сая төгрөг, нийт 4,663.8 сая төгрөгийг олгож, үр ашиггүй зардал гаргасан байна.

3.34. Аудитын явцад хөдөлмөрийн гэрээг үндэслэн олгосон 4,663.8 сая төгрөг болон нэр бүхий 2 хүнд шилжүүлсэн 131.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн анхан шатны баримтуудыг хувь хүний нууцлалтай холбоотой гэсэн шалтгаанаар үзүүлээгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.



БҮЛЭГ 4. Дотоод хяналтын тогтолцоог боловсонгүй болгох шаардлагатай байна

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартыг хэрэгжүүлээгүй байна

4.1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирлын 2007 оны 457 дугаар тушаалаар Дотоод аудитын хэлтсийг байгуулж, “Дотоод аудитын хэлтсийн журам”-ыг баталсан бөгөөд 2016 оны А/245 дугаар тушаалаар “Дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн найруулсан байна.

4.2. Дээрх журмын дагуу 2017 оны 3 дугаар улирлын байдлаар үйлдвэрийн ерөнхий захирлын дэргэдэх Дотоод аудитын хэлтэс үйл ажиллагаа явуулж байна.

4.3. Дотоод аудитын хэлтэс нь хэлтсийн дарга 1, орлогч дарга 1, тэргүүлэх нягтлан бодогч 1, инженер 2, эдийн засагч 2, нягтлан бодогч 4, нийт 11 орон тоотой байхаар зохион байгуулагдсан боловч 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 9 орон тоотойгоор ажиллаж байна.

4.4. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 06/2016 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо болон Дотоод аудитын албатай байхаар баталсан боловч Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2⁴⁹ дахь заалтыг үндэслэн ТУЗ-ийн 2016 оны 21/2016 дугаар тогтоолоор Аудитын хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар шийдвэрлэсэн байна.

4.5. Гэвч өнөөдрийг хүртэл хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын албыг байгуулаагүй байгаагаас “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт” хэрэгжээгүй явж иржээ.

Дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагаа үйлдвэрийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэгдээгүй байна

4.6. Дотоод аудитын хэлтсийн 2007-2016 он, 2017 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлантай танилцахад үйлдвэрийн цех, нэгж, хэсгүүдэд нийт 336 удаа хяналт шалгалт хийж, 991.3 тэрбум төгрөгийн 2239 алдаа, зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгснөөс 75.9-81.0 хувийг хэрэгжүүлсэн байна.

4.7. Энэ нь тус хэлтсээс явуулсан хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнд хүрсэн, үйлдвэрийн удирдлагыг үнэн, зөв бодитой мэдээллээр хангасан, хэлтэс, цех, нэгжүүдийн дотоод үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр ашгийг дээшлүүлэхэд илүү анхаарч ажилласныг нотолж байна.

4.8. Дотоод аудитын хэлтсийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үйлдвэрийн санхүүгийн, үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээнд суурилагүй, стратеги зорилттой уялдуулан төлөвлөөгүй байна.

4.9. Иймд Дотоод аудитын хэлтэс нь үйлдвэрийн цех, нэгж, хэсгүүдэд гарч байгаа алдаа зөрчлийг илрүүлж, түүнийг засч залруулахаас гадна үйлдвэрийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тогтоосон 2 төлбөрийн актыг барагдуулаагүй байна

4.10. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд 2012-2015 оныг хамруулан дараах аудитуудыг хийж, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 2 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгуулахаар 5 албан шаардлага, давхардсан тоогоор 100 зөвлөмж өгсөн байна.

⁴⁹ 81.2. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.



4.11. Аудитын явцад хөндлөнгийн аудитаар өгсөн нийт зөвлөмжөөс хэрэгжүүлэх шатанд байгаа болон хэрэгжээгүй дор дурдсан 43 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзлээ.

Хүснэгт № 16

Аудитаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн судалгаа

Аудитын нэр	Тогтоосон төлбөрийн актын тоо	Өгсөн зөвлөмжийн тоо	Аудитад хамруулан шалгасан зөвлөмжийн тоо
“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн н 2012 он, 2013 оны 3 дугаар улирлын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдэлийн аудит	2	22	22
Үндэсний аудитын газар, ОХУ-ын Тооцооны танхимын хамтарсан шалгалт /2014 оны 11 дүгээр сард хийсэн/		29	13
2014 оны санхүүгийн тайлангийн гэрчлэх аудит		49	8
Нийт дүн	2	100	43

Эх сурвалж: Аудитын судалгаа

4.12. Зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг дараах албан бичгээр хүргүүлж байжээ. Үүнд:

- Хамтарсан шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 9/310 дугаар “Материал хүргүүлэх тухай” албан бичгээр Үндэсний аудитын газарт,
- 2015 оны 10 сарын 16-ны өдрийн БУ-111-14/585 дугаартай “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр Оросын Холбооны Улсын Тооцооны танхимд,
- Эрсдэлийн аудитын дүнгээр өгсөн албан шаардлагын биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 9/310 дугаартай “Албан шаардлагын биелэлтийн тухай” албан бичгээр Үндэсний аудитын газарт.

4.13. Хөндлөнгийн аудитаас өгсөн дор дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлснээр нийт 111.4 тэрбум төгрөгийн үр өгөөж бий болгосон байна. Үүнд:

- Арилжааны банкуудад нээн ашиглаж байсан 8 харилцах данс, төлбөрт үйлчилгээний нэг кассыг хааснаас бэлэн мөнгөний гүйлгээ 2014 онд 16.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- Импортээр худалдан авч байсан Баяжуулах фабрикийн бутлуурын хуягийг Засвар механикийн заводод үйлдвэрлэдэг болсноор 2014 оны эхний хагас жилд 2.9 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж, “Оюу толгой” ХХК-ийн захиалгаар бутлуурын хуяг үйлдвэрлэн нийлүүлж, 30.0 сая төгрөгийн ашиг олсон.
- 2014 онд нийгмийн цехүүдийн орлого 0.6 тэрбум төгрөгөөр өсч, зардал 2.6 тэрбум төгрөгөөр буурсан, 2017 онд нийгмийн цехүүдийн зардал 2.4 пунктээр буурсан.
- 2014 оны эхний хагас жилийн байдлаар 39.7 тэрбум төгрөгийн авлага, 30.4 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.
- Гүйцэтгэгч байгууллагуудад төлөх урьдчилгаа төлбөрийг багасгаж, зайлшгүй шаардлагатай тохиолдолд 40 хүртэлх хувийн урьдчилгаа төлөх нөхцөлтэйгээр гэрээг байгуулснаар 2014 онд нийт 146.1 сая ам долларын гэрээнээс 93.1 сая ам долларын /93.1 сая доллар*1888.44=17.5 тэрбум төгрөг/ гэрээг урьдчилгаа төлбөргүй байгуулсан.

4.14. Хөндлөнгийн аудитаар өгсөн дараах 7 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- 1) Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг явуулах журмыг сонгож, төлөвлөөгүй, ихэвчлэн шууд гэрээгээр худалдан авалтыг хийсэн, урьдчилгаа төлбөртэй гэрээ байгуулж, 2015 оны жилийн эцсийн байдлаар 37.1 тэрбум төгрөг, 2016 онд 40.6 тэрбум төгрөг, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 40.2 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн байна.
- 2) 2011 оноос хойш НББ-ийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, 2017 онд шинэчлэн батлах ажил хийгдэж байна.
- 3) Уурхай хаагдах үеийн 39.7 тэрбум төгрөгийн “Газар нөхөн сэргээх сан”-г “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн бүртгэлд нөөцөөр бүртгэсэн боловч мөнгөн хөрөнгийн хомсдолтой байдлаас шалтгаалан тусгай дансанд байршуулаагүй байна.
- 4) “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын тушаалаар 2015 онд 307.5 сая төгрөг, 2016 онд 1,116.7 сая төгрөг, 2017 оны 3-р улирлын байдлаар 259.6 сая төгрөг, нийт 1,683.8 сая төгрөгийн хандив, тусламжийг иргэн, аж ахуйн нэгжид өгсөн байна.
- 5) Хараат болон охин компаниудын үр ашгийг нэмэгдүүлээгүй байна. Үүнд:
 - “Эрдэнэт үйлдвэр” ХХК гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байхад удаа дараа “Шим технологжи” ХХК-тай молибдений баяжмал нийлүүлэх гэрээг байгуулж 21.7 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн байна.
 - “Эрдэнэт-Ойл” ХХК-ийн байриил, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа нь галын аюулгүйн норм, дүрмийг ноцтой зөрчсөн, чанарын шаардлага хангахгүй, зөвхөн ОХУ-д үйлдвэрлэсэн машин техник, тоног төхөөрөмжид хэрэглэгдэх боломжтой тос, тосолгооны материалыг үйлдвэрлэж байгаа нь компанийн дүрмийн 5 дугаар зүйлийг зөрчсөн байна.
 - “Эрдэнэт-Ойл” ХХК нь 2010 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй зогссон нь тус компанид оруулсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болох эрсдэлийг дагуулж байна.



- “Эрдсүлж” ХХК нь ажлын хувцасны үйлдвэр бөгөөд 2006 онд байгуулагдсанаас хойш бараг ашиггүй ажиллаж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-нд ногдол ашиг хуваарилаагүй байна.

- 6) “Эрдэнэт”-ийн овоолгыг ашиглан гедрометаллургийн аргаар катодын зэс үйлдвэрлэх бүрэн хэмжээний үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх 2010.09.03-ны өдрийн 5/225-10 дугаартай гэрээг байгуулж, гэрээний 5.1-т ...техник технологийн ба эдийн засгийн үр ашигтай байдал нь үйлдвэрлэлийн туршилтаар амжилттай болсон тохиолдолд Зөвлөлийн зөвшөөрлөөр ...талууд урьдчилсан байдлаар /“Эрдэнэт үйлдвэр” ХХК овоолгын хүдрийг нийлүүлнэ 34 хувь, “Ачит Ихт” ХХК үйлдвэрийн барилгын ажлыг бүрэн санхүүжүүлнэ 66 хувь/ өнгөт металлын үйлдвэр барьж байгуулахаар тохироцлов... гэж заасан ч Зөвлөлд үйлдвэрлэлийн туршилт, эдийн засгийн үр дүнг танилцуулаагүй, зөвлөлийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр катодын зэс гаргах үйлдвэрийг барьж байгуулсан байна.
- 7) Хөдөлмөрийн гэрээг үндэслэн “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгагдаагүй эмчилгээний зардал, сургалтын төлбөр, ажлаас чөлөөгдсөний тэтгэмж болгон 2015 онд 13 хүнд 610.5 сая төгрөг, 2016 онд 18 хүнд 3,856.6 сая төгрөг, 2017 онд 2 хүнд 196.7 сая төгрөг, нийт 4,663.8 сая төгрөгийг олгож, үр ашиггүй зардал гаргасан байна.

4.15. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2013 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын явцад ажиллагсдын идээгүй хоолны зөрүү 2,703.8 сая төгрөгийг “Монгол катеринг” ХХК-д илүү шилжүүлснийг нөхөн төлүүлэхээр дараах 2 төлбөрийн актыг тогтоосон байна. Үүнд:

- 2013 оны 12 сарын 17-ны өдрийн 09/85 дугаар төлбөрийн актаар 112.3 сая төгрөг,
- 2013 оны 12 сарын 17-ны өдрийн 09/85 дугаар төлбөрийн актаар 2,591.5 сая төгрөг

4.16. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эдийн засаг хариуцсан орлогч, Ерөнхий нягтлан бодогч нар 2013 оны 2,591.5 сая төгрөгийн 09/85 дугаар төлбөрийн актыг зөвшөөрч гарын үсэг зурсан бөгөөд 112.3 сая төгрөгийн 09/85 дугаар төлбөрийн актад гарын үсэг зураагүй байна.

4.17. Монгол Улсын Ерөнхий аудиторт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 2014 оны ЦД-111-12-387 дугаар албан бичгээр дээрх 2 актыг “Монголиан катеринг” ХХК хүлээн зөвшөөрөхгүй, гэрээний дагуу үйлчилгээ үзүүлсэн, үйлдвэрийг хохироогоогүй гэж үзэн хууль, журмын үндэслэлийг хянуулах хүсэлт гаргасан боловч холбогдох хариуг өгөөгүй, ҮАГ-ын дэд дарга, тэргүүлэх аудиторын 2015 оны 115 дугаар албан бичгээр 2 төлбөрийн актыг биелүүлж ажиллахыг сануулж байжээ.

4.18. Дээрх 2 төлбөрийн акт нь дор дурдсан шалтгаанаар хэрэгжээгүй байна. Үүнд:

- o “Монголиан катеринг” ХХК 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Ажиллагсдад халуун хоолоор үйлчлэх гэрээ”-г урьдчилан цуцалсан тул “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 318.2 сая төгрөгийн хохирлыг төлүүлэхээр Орхон аймгийн Шүүхэд нэхэмжлэл гаргасан,
- o “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ҮАГ-аас тогтоосон 2013 оны 09/85 дугаар төлбөрийн актыг үндэслэн “Монголиан катеринг” ХХК-д 2.6 тэрбум төгрөг илүү шилжүүлсэн тухай сөрөг нэхэмжлэл гаргасан,
- o “Монголиан катеринг” ХХК 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ҮАГ-ын 2013 оны 09/85 дугаар актыг илт хууль бус болохыг тогтоолгох”-оор Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан тул Орхон аймгийн Шүүх тус маргааныг түдгэлзүүлсэн.

4.19. Авилгатай тэмцэх газраас ҮАГ-ын 2013 оны 09/85 дугаар төлбөрийн актад дурдсан “Монголиан катеринг” ХХК-д давуу байдал үүсгэн 2.5 тэрбум төгрөгийн гэрээ хийсэн талаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудаас мэдүүлэг авч, Эрүүгийн тухай хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн 170200180 тоот хавтаст хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагааг явуулж эхэлсэн байна. Авилгатай тэмцэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 06/8215 дугаар албан бичгийг үндэслэн Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хэргийг түдгэлзүүлэхээр хариуцагч болон гуравдагч этгээдийн талаас хүсэлт гаргасан байна.

4.20. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, Дотоод аудитын алба эрсдэлийн удирдлагыг сайжруулах талаар ач холбогдол бүхий зөвлөмж өгөөгүйтэй холбоотой байна.

4.21. Иймд хөндлөнгийн болон дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах нь зүйтэй байна.



ДҮГНЭЛТ

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн давтан аудитыг дараах 4 зорилтын хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан эсэхэд хийсэн дүгнэлт;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулаагүй байна.
- Гүйцэтгэх удирдлагууд худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллаагүй байна.
- Агуулахын үлдэгдлийг зохистой түвшинд хянаж нөөцийг тооцохгүйгээр худалдан авалт хийж, ашиглалтгүй болон илүүдэл хөрөнгийг бий болгосон байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн эсэхэд хийсэн дүгнэлт;

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн эзэмшлийн газарт үйл ажиллагаа явуулж буй хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлээгүй байна.
- Гүйцэтгэх удирдлага Зөвлөлийн шийдвэргүйгээр дур мэдэн их хэмжээний сонирхлын зөрчил бүхий гэрээг байгуулж, үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөл (Зөвлөл)-д Монгол Улсын хууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дүрэмд заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.
- Эрдэс, баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хянуулаагүй, дүгнэлтгүй ТЭЗҮ-ийг ашиглан хүдэр боловсруулах үйлдвэрийг байгуулж, үйлдвэрлэл, туршилт судалгааны ажлыг явуулж байна.
- Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил явуулах чиглэлээр байгуулсан газар ашиглуулах гэрээний заалтууд Газрын тухай хуульд нийцэхгүй байна.
- Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил явуулах чиглэлээр байгуулсан зарим гэрээ хүчин төгөлдөр бус, гэрээний заалтууд хэрэгжээгүй, талууд гэрээний үүргийн биелэлт, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
- Хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэрээнд заасан нөхцөлийн дагуу үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй, ашиглалтын болон газрын төлбөрийг дутуу авсан байна.

Бүтээгдэхүүн борлуулах, экспортод гаргах үнийг зохистой тогтоож, үр ашиггүй хөрөнгө оруулалт, зардлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлсэн эсэхэд хийсэн дүгнэлт;

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагууд Компанийн тухай хууль болон үйлдвэрийн Дүрмийн заалтуудыг зөрчин их хэмжээний хэлцэл хийж, борлуулалтын гэрээг байгуулсан байна.
- Зэсийн баяжмал хайлуулах болон цэвэршүүлэх зардал, молибдений баяжмалыг техникийн исэл болгоход гарах зардлыг үндэслэлгүй тогтоосон байна.
- Хөрөнгө оруулалтын зардал, үр ашгийн шинжилгээг бүрэн хийгээгүй, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулаагүйгээс хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт үр ашиггүй болжээ.



- “Шим технолоджи” ХХК борлуулалтын гэрээний 9.2, 9.4 дэх заалтыг зөрчин “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас худалдан авсан молибдений баяжмалын төлбөрийг бүрэн шилжүүлэхгүй өр үүсгэж байхад дахин гэрээ байгуулж, баяжмал нийлүүлэн өрийн хэмжээг нэмэгдүүлж, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 21.7 тэрбум төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгасан байна.
- Иргэн, аж ахуйн нэгжид хууль, журмыг зөрчин 1.7 тэрбум төгрөгийн хандив өгч, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 49.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулах болон хөдөлмөрийн гэрээний зардалд 4.9 тэрбум төгрөгийн, нийт 6.6 тэрбум төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэхэд хийсэн дүгнэлт;

- Дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагаа дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцэхгүй байна.
- Дотоод аудитын хэлтсийн үйл ажиллагаа бүтцийн нэгжүүдэд оршин байгаа алдаа зөрчлийг илрүүлж түүнийг засч залруулах талаар үр нөлөөтэй ажилласан боловч үйлдвэрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гарч болох алдаанаас урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлыг үнэлэх, дүгнэхэд чиглэгдээгүй байна.
- Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмжийн 16.3 хувийг хэрэгжүүлээгүй, тогтоосон 2 төлбөрийн актыг барагдуулаагүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах болон цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд:

1. Эрдэс, баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хянуулаагүй, дүгнэлтгүй ТЭЗҮ-ийг ашиглан Орхон аймгийн нутаг дэвсгэр дээр хүдэр боловсруулах үйлдвэр байгуулсан, туршилт судалгааны ажил явуулж байгаа “Ачит Ихт” ХХК, “Зэс Эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-ийн үйл ажиллагаа, хүдэр боловсруулах үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрлийн эрхтэй эсэхэд хяналт тавих, холбогдох арга хэмжээг авах.

Орхон аймгийн Засаг даргад:

1. Орхон аймгийн нутаг дэвсгэр дээр хүдэр боловсруулах үйлдвэр байгуулахаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай газар эзэмших, ашиглах гэрээ байгуулсан “Ачит Ихт” ХХК, “Зэс Эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК хүдэр боловсруулах үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөлтэй эсэх, газар ашиглах, эзэмших эрхийг холбогдох хууль, эрх зүйн акттай нийцүүлэн хяналт тавих, холбогдох арга хэмжээг авах.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээг Зөвлөлийн зөвшөөрөл, шийдвэргүй, холбогдох хуулийн заалтыг зөрчин байгуулсан, баталсан гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, эрх зүйн зөрчлийг арилгах холбогдох арга хэмжээг авах.
2. Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил хийх, газар ашиглуулах, газрыг хязгаарлагдмал эрхтэй эзэмшүүлэхээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг дахьин хянаж, хуульд нийцсэн шийдвэр гаргах,
3. Бүтээгдэхүүн борлуулах, экспортод гаргах үнийг ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалтыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дүрэмд тусгах,
4. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д төлөх “Шим технолоджи” ХХК-ийн өр төлбөрийн асуудлыг ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргах,
5. Дотоод аудитын Мэргэжлийн практикийн Олон улсын стандартад нийцүүлэн Дотоод аудитын албыг бий болгох,
6. Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангаж ажиллах.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захиралд:

1. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг явуулах журмыг оновчтой сонгон төлөвлөж, зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах,
2. Агуулахын зохистой нөөцөд тулгуурлан захиалгыг хянах, илүүдэл болон ашиглалтгүй хөрөнгийг эргэлтэд оруулах, ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулах үлдэгдлийг бууруулах талаар зохион байгуулж буй ажлыг эрчимжүүлэх,



3. Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг ТУЗ-д танилцуулж, хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах,
4. Монгол Улсын хууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дүрэмд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, үйлдвэрт үр ашигтай шийдвэр гаргах, онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг ТУЗ-д бүрдүүлж өгөх,
5. “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хянаж, ашиглалтын болон газрын төлбөрийг бүрэн авч, гэрээний хэрэгжилт үр дүнг тооцох, хуульд нийцүүлэх, гэрээг хүчингүй болгох,
6. “Шим технологжи” ХХК-иас авах молибдений баяжмалын төлбөрийн 21.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч, ТУЗ-д танилцуулж, шийдвэр гаргуулах,
7. ТУЗ-ийн шийдвэрээр батлагдсан бүтэц, үйлдвэрийн Дүрмийн холбогдох заалт, стандартад нийцүүлэн Дотоод аудитын хэлтсийн хараат бус байдлыг бүрэн хангахуйц байдлаар зохион байгуулалтын бүтцэд оруулж, түүний үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх,
8. “Монголиан катеринг” ХХК-тай холбоотой төлбөрийн актын асуудлыг шуурхай шийдвэрлэх,
9. Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тооцож хэвших.



Холбогдох байгууллагын санал

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2018 оны ХБ/111-12/209 дугаар албан бичгээр санал, тайлбарыг 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авч, холбогдох өөрчлөлтийг тайлангийн төсөлд тусгасан.

УАГ-ын Удирдлагын зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн 2018 оны 4 дүгээр сарын 23-нд дахын санал авахаар тайлангийн төслийг хүргүүлж, 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн БШ-111-12/375 дугаар албан бичгээр санал, тайлбарыг хүлээн авсан.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ДАВААНЯМ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05/992 тоот албан бичгээр ирүүлсэн Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн давтан аудитын тайлангийн төсөл, Албан шаардлагын төсөлтэй танилцлаа.

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн зүгээс Үндэсний аудитын газартай бүх талаар хамтран ажиллаж, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, илэрсэн аливаа зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байхад онцгойлон ач холбогдол өгч, зохих арга хэмжээ авч ажиллаж байна гэдгийг дахин илэрхийлье.

Энэ удаагийн давтан аудитын шалгалтын тайланд тусгагдсан зарчмын нэлээд хэдэн асуудалд Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн өгөх тайлбар, саналыг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ХБ-111-12/209 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр манай компанид ирүүлсэн аудитын тайлан, дүгнэлтийн төслийг судалж үзээд Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн өгөх тайлбар, саналыг дахин хүргүүлж байна.

Манай компанийн саналыг давтан аудитын тайлан, дүгнэлтэд тусгаж өгөхийг дахин хүсье.

Үндэсний аудитын газрын давтан аудитын тайлан, Албан шаардлагын төсөлд өгөх тайлбар, саналыг хавсаргав.

Хавсралт хуудастай.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Х.БАДАМСҮРЭН

001739



Үндэсний аудитын газрын тайлбар

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн БШ-111-12/375 дугаар албан бичгээр 22 заалт бүхий тайлбар, 12 заалт бүхий санал ирүүлснийг судалж, тайлангийн төсөлд дараах байдлаар өөрчлөлт оруулав.

№	Санал авахаар хүргүүлсэн тайлангийн төсөлд тусгагдсан асуудлууд	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас ирүүлсэн санал	Саналыг хүлээн авч, тайлангийн төсөлд өөрчлөлт оруулсан асуудлууд
1	2.28. “Ачит Ихт” ХХК-ийн төлсөн ашиглалтын төлбөрийн дүнг аудитаар тооцоолсон дүнтэй харьцуулахад гэрээнд 2014 онд төлөх хувь хэмжээг тусгаагүйгээс 91.4 сая төгрөгийн ашиглалтын төлбөрийг огт тооцоогүй, 2015-2017 онд 408.8 сая төгрөгийг дутуу тооцсон зэрэг зөрчил илэрсэн тул дутуу тооцсон 408.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.	“Ачит Ихт” ХХК-ийн борлуулалтыг орлогын зөрүү болон уг зөрүүд ногдох НӨАТ-ын зөрүү байна. Давтан аудитын тайлангийн төслийн 2.23 дахь заалтанд уг зөрүүг “Ачит Ихт” ХХК-ын тайлангаарх борлуулалтын орлого болон гаалийн бүрдүүлэлт, экспортод гаргасан барааны тоо хэмжээ, статистик дүнгээс тооцсон валютын ханшийн зөрүү гэсэн агуулгаар орсон тул тайлангийн уг заалтын агуулгын өөрчлөн найруулах саналтай байна.	Саналыг хүлээн авч дараах байдлаар өөрчлөлт оруулав. 2.28. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь “Ачит Ихт” ХХК-ийн борлуулсан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын дүнг валютын ханштай уялдуулан ашиглалтын төлбөрийг зөв ногдуулсан эсэхийг хянадаггүй, ашиглалтын төлбөрийг нэмэгдсэн өртгийн албан татвар тооцоогүй дүнгээр хүлээн авснаас шалтгаалан “Ачит Ихт” ХХК /НӨАТ төлөгчийн 2011 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 46102 дугаар гэрчилгээ эзэмшигч/-ийн ашиглалтын төлбөрийг 2015-2017 онд 408.8 сая төгрөгийг дутуу тооцсон зөрчил илэрсэн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.
2	“Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 5/199-14 дугаар гэрээний 1.4, 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан 5/33014 дугаар гэрээний 1.5-т “ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцаж байгаа 116.2 гектар талбайн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3,34.2-т заасны дагуу жил бүр 1743 ам.долларыг, эдэлбэр газартай давхцаж буй 40.96 гектарын төлбөрийг Газрын тухай хууль, ЗГ-ын тогтоолын дагуу жил бүр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дансанд жил бүрийн 1-р сард төлнө” гэж заасан боловч талууд газрын төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулаагүй, Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасан өөрчлөлтөөр төлбөрийг зөв ногдуулаагүйгээс нийт 17,580.2 мянган төгрөгөөр дутуу тооцсон байгаа тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.	Актын төлбөрийн дүнг 9,998,197.21 төгрөг болгох саналтай байна.	Саналыг хүлээн авч дараах байдлаар өөрчлөлт оруулав. “Газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр эзэмшүүлэх тухай” 2014 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 5/199-14 дугаар гэрээний 1.4-т заасны дагуу /2014.05.19-ны өдрөөс 2014.09.14-ны өдөр хүртэл 115 хоногт ногдох төлбөрийг 549.2 ам.доллар буюу 1,012.8 мянга/, 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан 5/33014 дугаар гэрээний 1.5-т заасны дагуу /2014.09.15-ны өдрөөс 2015.01.22-ны өдөр хүртэл 126 хоногт ногдох төлбөрийг 585.6 ам.доллар буюу 1,169.9 мянга/ Ашигт малтмалын тухай хуулийн 32.3-т “...уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар...” дагуу тооцохдоо нийт 1120.2 ам.доллар буюу 2,182.7 мянган төгрөг тооцож авахаас 1,394.7 мянган төгрөгөөр дутуу, эдэлбэр газартай давхцаж буй 40.96 гектар газрын төлбөрийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын дагуу тооцохдоо нийт 32,453.8 мянган төгрөгөөр тооцож авахаас 2,416.4 мянган төгрөгөөр дутуу, мөн 2014 оны газрын төлбөрийг тухайн онд нь тооцож аваагүйгээс 6,187.0 мянган төгрөгийг аваагүй, газрын төлбөрийг



			нийт 9,998.2 мянган төгрөгөөр дутуу тооцсон зочил илэрсэн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.
3	3.25. Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2015 онд 292.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 82.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, 2016 онд 50,242.9 сая төгрөгийн анхны өртөгтэй 50,242.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, 2017 онд 416.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 196.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, нийт 50,951.8 сая төгрөгийн анхны өртөгтэй 49,844.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг байгууллага, хувь хүнд үйлдвэрийн Ерөнхий захирлын тушаалыг үндэслэн шилжүүлсэн байна. 3.26. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30-р зүйлийн 1-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, 2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.” гэж заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.	Эрдэнэт медиал төв эмнэлэгийн барилга, байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад эргэлтийн хөрөнгийг Медипас нийгэмлэг, Медипас ХХК-тай байгуулсан 2015 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Санамж бичиг, Эрдэнэт медиал төв эмнэлгийн үйл ажиллагааны тухай 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн № 5/262-15 тоот гэрээ, санхүү, эдийн засаг, тооцооны ажлын дэд хэсгийн акт болон Ерөнхий захирлын 2016 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А/108 тоот тушаалыг үндэслэн 2016 оны 6 дугаар сард нийт 64,871,553,622.27 өртөгтэй хөрөнгийг Медипас ХХК-д шилжүүлж, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн үндсэн хөрөнгө, бусад хөрөнгийн данснаас хасч, уг дүнгээр урт хугацаат авлага дансанд бүртгэсэн. Гэрээний дагуу Медипас ХХК шилжүүлж авсан хөрөнгийн төлбөрийг 3 дахь жилээс эхлэн 18 жилийн хугацаанд төлөх бөгөөд эхний 2 жилд төлбөр төлөхгүй нөхцөлтэй. Эрдэнэт үйлдвэр ХХК болон Медипас нийгэмлэг, Медипас ХХК-ийн хооронд байгуулах эдгээр гэрээг Хамтарсан үйлдвэрийн Зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 51 дүгээр хуралдаан (хуралдааны протоколын 9.9 дэх заалт)-аар хэлэлцэж, чиглэл өгсөн. Тиймээс (а) Медипас ХХК-д эдгээр хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлээгүй, хөрөнгөтэй холбогдох тооцоог компанийн санхүүгийн байдлын тайланд урт хугацаат авлагаар илэрхийлсэн бөгөөд гэрээний дагуу хуваарьтайгаар төлүүлэх тул (б) эрх бүхий удирдлагын гаргасан шийдвэр болон гэрээ, хэлцлийн дагуу хөрөнгийг шилжүүлсэн тул албан шаардлагаас хасах саналтай байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 1/665 тоот албан бичгээр Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн албан хэрэгцээнд ашиглаж байгаа 04-05 УНТ улсын дугаартай LEXUS LX-570 маркийн суудлын автомашиныг шилжүүлж өгөхийг мэдэгдсэн. Түүний дагуу Ерөнхий захирлын “Авто машин шилжүүлэх тухай” 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/788 тоот тушаал гарч, автомашиныг шилжүүлж өгсөн. Харин Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас автомашины өртгийг хэрхэн шийдвэрлэх талаар ямар нэг чиглэл, шийдвэр ирээгүй тул компанийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөөс хасч, авлага дансанд шилжүүлж бүртгэсэн ба одоогоор авлагын дансанд үлдэгдэлтэй хэвээр байна. Тиймээс мөн (а) уг хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлээгүй, хөрөнгөтэй холбогдох тооцоог компанийн санхүүгийн байдлын тайланд авлагаар илэрхийлсэн ба компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг хүлээж байгаа, (б) уг хөрөнгийг Төрийн өмчийн бодлого,	Тус асуудал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30-р зүйлийн 1-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, 2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.” гэж заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгснийг өөрчлөх боломжгүй байна.



		зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу шилжүүлсэн тул актын төслөөс хасах саналтай байна.	
4	3.32. Зах зээлийн ханшнаас хэт өндөр үнээр орон сууц түрээслэх, орон сууцны хэрэглээний зардлыг ам.доллараар төлөх гэрээг байгуулж, 2014-2015 онд 104.8 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагатай байна.	"Эрдэнэт Үйлдвэр" ХХК болон иргэн Д.Дуламсүрэн нарын хооронд байгуулсан гэрээний төлбөрт тухайн 201, 501, 502 тоотод амьдарч буй өрхүүдийн цэвэр, бохир ус, цахилгаан, дулааны хэрэглээнээс гадна харуул хамгаалалт, засвар үйлчилгээ, галын дохиолол, видео хяналт, ногоон байгууламж, холбоо мэдээлэл, түрээсийн төлбөр болон гурван машины зогсоолтой холбоотой ашиглалтын зардлууд багтдаг болно. 2014-2015 онд 104.8 сая төгрөгийн зардал гараагүй. Гэрээг ам.доллараар хийсэн боловч төлбөрийг тухайн үеийн Монгол банкны ханшаар тооцон төгрөгөөр төлж байсан, 2013-2016 онд нийт 83.9 сая төгрөг төлж байсан ба мөн эдгээр өрхүүдийн 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэл хэрэглээний зардал болон бусад зардлыг компани болон оршин суугчдаас төлөөгүй байна. 2 тал уг төлбөрийг төлөлгүйгээр харилцан суутгахаар тохиролцож байгаа тул эдгээр заалтыг хасах саналтай байна.	3.27. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2012 оны 12 дугаар сард 5/017-13 дугаар “Орон сууц барих тухай гэрээ”-г “Ижилманлай” ХХК-тай байгуулж, гэрээнд заасны дагуу дараах гүйлгээгээр 2 орон сууцны үнийг төлжээ. Үүнд: 2013 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 246 дугаар төлбөрийн даалгавараар 100.0 сая төгрөг, 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 354 дүгээр төлбөрийн даалгавараар 100.0 сая төгрөг, 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 533 дугаар төлбөрийн даалгавараар 243.5 сая төгрөг, 2013 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 1799 дүгээр төлбөрийн даалгавараар 166.3 сая төгрөг, нийт 609.8 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. 3.28. “Ижилманлай” ХХК-ийн нэхэмжлэл болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас 2013 оны 2,3 дугаар сард шилжүүлсэн төлбөрийн даалгавар дээр зурагдсан 1 дүгээр гарын үсэг 1 хүнийх байх магадлалтай байгаа тул холбогдох байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байна. Эдгээр асуудлууд нь ашиг сонирхлын зөрчил үүсгэн гэрээ байгуулж, худалдан авсан, өөрийн эзэмшлийн орон сууцыг өндөр үнээр түрээслэсэн байж болзошгүй байгаа тул хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байгаа тул тайлангийн төслөөс хасах боломжгүй байна.
5	3.33. Хөдөлмөрийн гэрээг үндэслэн “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгагдаагүй эмчилгээний зардал, сургалтын төлбөр, ажлаас чөлөөгдсөний тэтгэмж болгон 2015 онд 13 хүнд 610.5 сая төгрөг, 2016 онд 18 хүнд 3,856.6 сая төгрөг, 2017 онд 2 хүнд 196.7 сая төгрөг, нийт 4,663.8 сая төгрөгийг олгож, үр ашиггүй зардал гаргасан байна. (Хавсралт № 11)	2016 оны 7 дугаар сараас өмнөх хугацаанд Компани нь Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК гэсэн статустай, үйл ажиллагаа нь Олон улсын гэрээний тухай Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан Монгол Улсын Засгийн Газар болон Оросын Холбооны Улсын Засгийн Газар хоорондын 2003 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хэлэлцээр болон уг хэлэлцээрийн дагуу батлагдсан Компанийн дүрэм, Зөвлөлийн шийдвэр дагуу Ерөнхий захирал, I орлогч захирал болон Ерөнхий захирлын эрх хэмжээний хүрээнд компанийн бусад удирдахь албан тушаалтан, ажилтнуудтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээний нэмэлт, контрактын дагуу олгосон хөнгөлөлт, урамшуулал,	Аудитын явцад хөдөлмөрийн гэрээг үндэслэн олгосон 4,663.8 сая төгрөг болон нэр бүхий 2 хүнд шилжүүлсэн 131.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн анхан шатны баримтуудыг хувь хүний нууцлалтай холбоотой гэсэн шалтгаанаар үзүүлээгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэсэн тул тус асуудлыг тайлангийн төслөөс хасах боломжгүй байна.



	3.34. Аудитын явцад хөдөлмөрийн гэрээг үндэслэн олгосон 4,663.8 сая төгрөг болон нэр бүхий 2 хүнд шилжүүлсэн 131.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн анхан шатны баримтуудыг хувь хүний нууцлалтай холбоотой гэсэн шалтгаанаар үзүүлээгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.	нөхөн олговрыг олгосон байдаг. Эдгээр хөнгөлөлт, урамшуулал, нөхөн олговор нь хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, түүнд холбоотой эрх зүйн баримт бичгийн хүрээнд явагдсан тул хууль бус гэж үзэж хувь хүнээр нөхөн төлүүлэх үндэслэлгүй бөгөөд боломжгүй юм. Иймд эдгээр хөнгөлөлт, урамшуулал, нөхөн олговрын талаарх 3.33 ба 3.34 дэх заалтыг хасах саналтай байна.	
6	Зөвлөмжийн хэсэгт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд: Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээг Зөвлөлийн зөвшөөрөл, шийдвэргүй, холбогдох хуулийн заалтыг зөрчин байгуулсан, баталсан гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, эрх зүйн зөрчлийг арилгах холбогдох арга хэмжээг авах.	Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулсан үйл ажиллагаа нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх Засгийн газрын бодлоготой нийцэж байгаа бөгөөд тухайн үед Зөвлөлийн удаа дараагийн хуралд танилцуулж, зохих чиглэл авч байсан болно. Энэ талаар тайлангийн 2.3.-д тодорхой заасан байна. Иймд “... гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох ...” гэсэн хэсгийг хасах саналтай байна. Мөн эдгээр гэрээ, хэлцлийг байгуулж байх үед ажиллаж байсан гүйцэтгэх удирдлагын албан тушаалтнууд Эрдэнэт үйлдвэрт ажиллахгүй байгаа тул уг зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй.	Зөвлөмжийн хэсэгт “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд: Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээг Зөвлөлийн зөвшөөрөл, шийдвэргүй, холбогдох хуулийн заалтыг зөрчин байгуулсан, баталсан гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, эрх зүйн зөрчлийг арилгах холбогдох арга хэмжээг авах гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.
7	Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил хийх, газар ашиглуулах, газрыг хязгаарлагдмал эрхтэй эзэмшүүлэхээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг дахын хянаж, хуульд нийцсэн шийдвэр гаргах,	Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил хийх, газар ашиглуулах, газрыг хязгаарлагдмал эрхтэй эзэмшүүлэхээр байгуулсан гэрээнүүдийг компанийн зүгээс хууль бус гэж үзэхгүй байна. Иймд энэ талаар компанийн ТУЗ-д зөвлөмж өгөх шаардлагагүй тул хасах саналтай байна. Харин эдгээр гэрээний нөхцөлийг сайжруулах чиглэлээр дахын хянаж, байгуулах зөвлөмжийг Ерөнхий захиралд өгөх нь зүйтэй байна.	Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах, туршилт судалгааны ажил хийх, газар ашиглуулах, газрыг хязгаарлагдмал эрхтэй эзэмшүүлэхээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг дахын хянаж, хуульд нийцсэн шийдвэр гаргах гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.
8	Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Аудитын тайлангийн 4-р бүлэгт 2012-2015 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тухай дурьдсан байх бөгөөд тухайн үед ажиллаж байсан гүйцэтгэх удирдлага буюу Ерөнхий захирал, орлогчид болон ерөнхий нябо нар одоо компанид ажилладаггүй. Иймд энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй тул хасах саналтай байна.	Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.
9	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захиралд: Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг ТУЗ (Зөвлөл)-д танилцуулж, хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах,	Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр байгуулсан гэрээнүүдийг компанийн зүгээс хууль бус гэж үзэхгүй байна. Иймд “...хүчин төгөлдөр бус...” гэснийг хасах саналтай байна.	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захиралд: Хүдэр боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг ТУЗ-д танилцуулж, хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.
10	Монгол Улсын хууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дүрэмд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, үйлдвэрт үр ашигтай шийдвэр	“... онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх, нөхцөлийг ТУЗ /Зөвлөл/-д бүрдүүлж өгөх” гэсэн нь Ерөнхий захирлын эрх хэмжээний хүрээнд хамаарахгүй асуудал тул энэ заалтыг хасах саналтай байна.	Монгол Улсын хууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дүрэмд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, үйлдвэрт үр ашигтай шийдвэр гаргах,



	гаргах, онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг ТУЗ (Зөвлөл)-д бүрдүүлж өгөх,		онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг ТУЗ-д бүрдүүлж өгөх гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.
11	“Ачит Ихт” ХХК, “Зэс Эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хянаж, ашиглалтын болон газрын төлбөрийг бүрэн авч, гэрээний хэрэгжилт, үр дүнг тооцож, гэрээний заалтыг хуульд нийцүүлэн хүчингүй болгох.	“...хуульд нийцүүлэн хүчингүй болгох” гэдгийг “...хуульд нийцүүлэн өөрчлөх” гэсэн агуулгаар өөрчлөх саналтай байна.	Саналыг хүлээн авч дараах байдлаар өөрчлөлт оруулав. “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хянаж, ашиглалтын болон газрын төлбөрийг бүрэн авч, гэрээний хэрэгжилт үр дүнг тооцох, хуульд нийцүүлэх, гэрээг хүчингүй болгох,
12	Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тооцож хэвших.	Аудитын тайлангийн 4-р бүлэгт 2012-2015 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тухай дурьдсан байх бөгөөд тухайн үед ажиллаж байсан гүйцэтгэх удирдлага буюу Ерөнхий захирал, орлогчид болон ерөнхий нябо нар одоо компанид ажилладаггүй. Иймд энэ зөвлөмжийн “... хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох ...” гэсэн хэсгийг хэрэгжүүлэх боломжгүй тул хасах саналтай байна.	Хөндлөнгийн болон Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох, цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тооцож хэвших гэсэн зөвлөмжийг цаашид анхаарч ажиллахыг анхааруулж өгсөн тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.



Тайланг баталгаажуулсан Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дах заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам батлах тухай" журмын 4.2, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн давтан аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /У.Бямбасүрэн/, "Эрдэнэт үйлдвэр" ХХК /Х.Бадамсүрэн/-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зарим зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Аудитын явцад илэрсэн зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс /тоогоор/			
		Тоо	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Зөвлөмж	Акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн асуудал
<i>A</i>	<i>I</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	<i>7</i>
1	“Эрдэнэт үйлдвэр” ХХК	16	1,120,658.2	9	2	1	4



Хавсралтууд

Хавсралт № 1

Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 2015, 2016 он болон 2017 оны 3-р улиралд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны нэгтгэсэн судалгаа

(сая төгрөгөөр)

Төсөвт өртгийн хязгаар	бараа			Барилга, их засварын ажил			зөвлөх үйлчилгээ			нийт дүн		
	гэрээний тоо	мөнгөн дүн	эзлэх хувь	гэрээний тоо	мөнгөн дүн	эзлэх хувь	гэрээний тоо	мөнгөн дүн	эзлэх хувь	гэрээний тоо	мөнгөн дүн	эзлэх хувь
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
шууд гэрээгээр	9	61.8	0.0	34	202.0	0.3	4	115.4	1.6	47	379.2	0.0
харьцуулалтын аргаар	248	25,424.4	2.7	213	8,719.6	13.0			-	461	34,144.0	3.4
нээлттэй тендер шалгаруулалтаар	848	917,834.8	97.3	130	58,328.9	86.7	24	7,056.0	98.4	1,002	983,219.7	96.6
НИЙТ ДҮН	1,105	943,321.0	100.0	377	67,250.5	100.0	28	7,171.4	100.0	1,510	1,017,742.9	100.0
шууд гэрээ байгуулсан	847	918,368.2	97.4	214	18,688.3	27.8	28	7,171.4	100.0	1,089	944,227.9	92.8
харьцуулалтын аргаар	209	8,830.7	0.9	137	43,212.1	64.3			-	346	52,042.8	5.1
нээлттэй тендер шалгаруулалтаар	49	16,122.1	1.7	26	5,350.1	8.0			-	75	21,472.2	2.1
НИЙТ ДҮН	1,105	943,321.0	100.0	377	67,250.5	100.0	28	7,171.4	100.0	1,510	1,017,742.9	100.0

Эх сурвалж: "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Хангамжийн хэлтэс, Их барилгын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн судалгаа



“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ашиглалтын болон эдэлбэр газруудад үйл ажиллагаа явуулж буй гадны компанийн газар ашиглалтын судалгаа

№	нэгж талбарын нэр	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ний ашиглалтын газар /га/	Гадны байгууллагуудын ашиглаж байгаа газар / га/				Гадны байгууллагын ашиглаж байгаа нийт газар /га/	тухайн нэгж талбарт эзэлж буй хувь
			"Ачит ихт" ХХК	"Эрдмин" ХХК	"ДэБэТэ" ХХК	"Зэс эрдэнийн хувь" ХХК		
1	Уурхайн нөөц талбай	1640.91	0	0	0	0	0	-
2	уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж буй талбай	900	116.2	70.82		60	247.02	27.45
3	үйлдвэрийн барилга байгууламжийн талбай	1187.1	40.1		7.727	0.5	48.327	4.07
4	тэсрэх дэлбэрэх бодисын агуулах	309	0.86				0.86	0.28
5	Хаягдлын аж ахуйн ашиглалт явуулж буй талбай	7255						
6	Нэр бүхий зориулалт,ангилалттай бусад газар	161.7291						
	Нийт дүн	11,453.739	157.16	70.82	7.727	60.5	296.207	2.59



“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлд танилцуулаагүй, хуралдаанаар хэлэлцүүлээгүй, зөвшөөрөл, шийдвэргүй асуудлын судалгаа

Зөвлөлд танилцуулаагүй, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээгүй	Зөвлөлийн зөвшөөрөл, шийдвэргүй
“Ачит Ихт” ХХК-тай байгуулсан дараах гэрээ, санамж бичгүүд: 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт ...хамтарсан үйлдвэрийн статус “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлөөр батлагдана...; 2012 оны 06 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Санамж бичиг”-т...“Ачит Ихт” ХХК-д 2 дугаар овоолгыг ашиглуулан боловсруулах үйлдвэр барихыг зөвшөөрсүгэй, ...“Ачит Ихт” ХХК-ийн г хамтарсан үйлдвэрээр бүртгүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн баримтуудыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Зөвлөлөөр батлуулахаар бэлтгэх...; 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн АИ-13/02 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-нд ...“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн н дүрмийн дагуу 2013 онд багтаан компанийн зөвлөлийн хурлаар батлуулна, ...зөвлөлийн хурлаас дэмжигдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно...; “Зэс эрдэнийн хувь” ХХК-тай 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 5/096-13 дугаар Хамтран ажиллах гэрээний үндэслэлд ...ТӨХ-ны Тамгын газрын даргын 2012 оны 05 дугаар сарын 09-ний 16/919 дугаар албан бичигт: ...компанийн дүрэмд заасны дагуу “Зэс Эрдэнийн хувь” ХХК-иас тавьж буй асуудлаар гарах шийдвэр нь хамтарсан үйлдвэрийн зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах учраас Оросын хэсгийн саналыг авсны үндсэн дээр Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх...;	“Ачит Ихт” ХХК-тай байгуулсан дараах гэрээ, санамж бичгүүд: 2010 оны 09 дүгээр 03-ны өдрийн 5/225-10 дугаартай “Эрдэнэт”-ийн овоолгийг ашиглан гедрометаллургийн аргаар катодын зэс үйлдвэрлэх бүрэн хэмжээний үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх” гэрээний 5.1-т ...техник технологийн ба эдийн засгийн үр ашигтай байдал нь үйлдвэрлэлийн туршилтаар амжилттай болсон тохиолдолд Зөвлөлийн зөвшөөрлөөр ...талууд урьдчилсан байдлаар /“Эрдэнэт үйлдвэр” ХХК овоолгын хүдрийг нийлүүлнэ 34 хувь, “Ачит Ихт” ХХК үйлдвэрийн барилгын ажлыг бүрэн санхүүжүүлнэ 66 хувь/ өнгөт металлын үйлдвэр барьж байгуулахаар тохиролцов...; 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн №5/199-15 дугаар гэрээний үндэслэлд ...Монгол Улсын Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 ...Хуулийн этгээд удирдахь байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно...; “Эрдэнэт” концерн, Америкийн “Ар Си Эм” корпорацийн хооронд 1994 оны 03 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан гэрээний /аудитаар гэрээг үзүүлээгүй/ дагуу катодын зэс үйлдвэрлэх “Эрдмин” ХХК-ийн г 100.0 мян.ам.долларын дүрмийн сантай анх үүсгэн байгуулсан...;



Гэрээний хэрэгжээгүй заалтын судалгаа

Компанийн нэр	Гэрээний огноо, дугаар	Гэрээний заалтууд
“Ачит Ихт” ХХК	2010 оны 5/225-10 дугаар гэрээ	2.2.1-д “төслийг удирдахь, балансын гадуурх овоолгоос зэс ялгах SX-EW аргын технологийг боловсруулж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай зөвшилцөх... гэж заасан ч уг гэрээний хэрэгжилтийг дүгнэх Хамтарсан ажлын хэсгийн гаргасан дүгнэлтэд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай зөвшилцөлгүй ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн” гэж дурдсан байна, 5.1-д ...техник технологийн ба эдийн засгийн үр ашигтай байдал нь үйлдвэрлэлийн туршилтаар амжилттай болсон тохиолдолд Зөвлөлийн зөвшөөрлөөр ...талууд урьдчилсан байдлаар /“Эрдэнэт үйлдвэр” ХХК овоолгын хүдрийг нийлүүлнэ 34 хувь, “Ачит Ихт” ХХК үйлдвэрийн барилгын ажлыг бүрэн санхүүжүүлнэ 66 хувь/ өнгөт металлын үйлдвэр барьж байгуулахаар тохиролцов.
	2013 оны АИ-13/02 дугаар гэрээ	2.2-т “А” ⁵⁰ тал компанийн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахад шаардлагатай балансын бус хүдэр өгч байгааг үндэслэн “Ачит Ихт” ХХК-ийн н хувь хөрөнгийн 34 хувийг эзэмшинэ гэсэн заалт хэрэгжээгүй,
	2015 оны 5/199-15 дугаар гэрээ	1.1-д “...харилцан ашигтай байх нөхцлийг тодорхойлох... гэж заасан боловч 2014 онд боловсруулсан ТЭЗҮ-д ...Эрдэнэт үйлдвэр нь “Ачит Ихт” ХХК-ийн 34%-ийг эзэмшихээр ярилцаж байгаа... гэж тусгасан нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК тус үйлдвэрийн 34%-ийг эзэмшээгүй, талууд харилцан ашигтай байх нөхцлийг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй байна, 2.5-д “Б” ⁵¹ тал нь борлуулсан катодын зэсийн улирал бүрийн мэдээг дараа улирлын эхний сарын 25-ны дотор “А” талд хүргүүлнэ ...гэж заасан ч “Ачит Ихт” ХХК-аас улирал бүрийн баталгаажсан мэдээ тайланг ирүүлдэггүй, тус компаниас ашиглалтын төлбөрт шилжүүлсэн төлбөрийг авдаг, 2.6-д “Б” тал нь ОУ-ын нэр хүнд бүхий, ашиг сонирхлын зөрчилгүй, Монгол Улсад аудит хийх эрхтэй компаниар аудит хийлгэсэн жил бүрийн борлуулалтын орлогын тайланг дараа жилийн эхний улиралд багтаан “А” талд хүргүүлнэ... гэж заасан боловч гэрээ байгуулснаас хойш борлуулалтын орлогын тайланг А талд огт ирүүлээгүй, “Эрдэнэт үйлдвэр” ХХК ашиглалтын төлбөр төлөөгүй дүнгээр тооцооны үлдэгдлийн баталгааг гаргаж, төлбөрийг нэхэмжилсэн байна. “Ачит Ихт” ХХК-ийн үйлдвэрлэсэн болон борлуулсан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын орлогын дүнг баталгаажуулсан тайлан, мэдээ байхгүй байна. 3.5-т “А” тал нь гэрээний биелэлт, үндсэн үйл ажиллагааны явцын талаар мэдээлэл хийхийг “Б” талаас шаардаж холбогдох мэдээллийг тухай бүр гаргуулж авна... гэсэн заалт огт хэрэгжээгүй, “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь катодын зэсийн үйлдвэрлэл, борлуулсан катодын зэсийн тоо хэмжээ, борлуулалтын орлогын дүнг, дэлхийн зах зээлийн дундаж үнэ, валютын ханштай уялдуулан ашиглалтын төлбөрийн тооцооллыг зөв ногдуулсан эсэхийг хянаж чаддаагүй байна.
”Зэс-Эрдэнийн хувь” ХХК	2013 оны 5/096-13 дугаар гэрээ	4.5-д “туршилт судалгааны ажлын үр дүнг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д танилцуулна”, 5.2-т “туршилт судалгааны үр дүн, эдийн засгийн үр ашгийн тооцооллыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д танилцуулна” гэж заасан ч тус үйлдвэрт туршилт судалгааны үр дүн, эдийн засгийн үр ашгийн тооцооллыг танилцуулсан эсэх нь тодорхойгүй, 9.2-т “Хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүн эдийн засгийн үр ашигтай гэж тогтоогдсон тохиолдолд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлнэ... гэж заасан ч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлээгүй”.
	2015 оны 5/277-15 дугаар гэрээ ⁵²	2.1-д “Катодын зэс гарган авах үйлдвэрийг “В” ⁵³ талын хөрөнгө, санхүүжилтээр гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 3 /гурван/ жилийн хугацаанд барьж байгуулна” гэж заасан ч одоогоор үйлдвэрийг барьж эхлээгүй.

⁵⁰ “Эрдэнэт үйлдвэр” ХХК⁵¹ “Ачит Ихт” ХХК⁵² гэрээг 20 жилийн хугацаатай байгуулсан⁵³ “Зэс эрдэнийн хувь” ХХК



	2016 оны 5/279-14 дугаар гэрээ	5.1-д “Б” тал туршилт судалгааны үр дүнг “А” талд танилцуулна... гэж заасан ч “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д туршилт судалгааны үр дүнг танилцуулсан эсэх нь тодорхойгүй, 7.1-д Гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар эхэлж дээж авснаар дуугавар болно..., 7.2-т 8а, 12 дугаар овоолгуулаас хүдрийн дээжийг авах үйл ажиллагааг “Б” талын захиалгаар 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 31-ний өдрийн хооронд “В” тал гүйцэтгэнэ... гэж заасан ч дээж авагдсан эсэх нь тодорхойгүй, гэрээний үйлчлэх хугацаа 2016 оны 10 дүгээр сарын 04-нд дуусгавар болсныг талууд дүгнээгүй, 10.1.1-д Гэрээний хугацаанд “Б” тал овоолгуудаас дээж авах ажлыг эхлүүлээгүй бол гэрээ цуцлах гэж заасан ч гэрээг цуцалсан эсэх нь тодорхойгүй.
“Морьт Эксплорейшн” ХХК	2012 оны 5/251-12 дугаар гэрээ	1-д “компани” нь баяжуулах фабрикийн хаягдлаас үлдэгдэл металл ялган авах технологи боловсруулах судалгаа шинжилгээ, туршилж явуулах, ТЭЗҮ боловсруулах, үйлдвэр барьж байгуулах цогц ажлыг гүйцэтгэх... гэж заасан ч цогц ажлыг гүйцэтгээгүй, 5-д уг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд “Компани” судалгаа шинжилгээний ажлыг дуусгаж, ТЭЗҮ боловсруулан үйлдвэр байгуулах асуудлыг шийдээгүй тохиолдолд энэхүү гэрээг хүчингүйд тооцно... гэж заасан ч судалгаа шинжилгээний ажил дуусаагүй, боловсруулсан ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хянуулаагүй, гэрээний үйлчлэх хугацаа 2017 оны 07 дугаар 18-ны өдөр дууссан ч гэрээний үр дүнг талууд дүгнээгүй.
	2015 оны 5/239-15 дугаар гэрээ	1.3-т “ДэБЭТэ” ХХК нь нийт 7,727 га талбай бүхий эдэлбэр газрын төлбөрийг Газрын тухай хууль, Монгол Улсын ЗГ-ын тогтоолын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн н дансанд жил бүрийн 1-р сард багтаан төлнөгэж заасан ч үүргээ хэрэгжүүлээгүй, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д газрын төлбөрт нэг ч төгрөг төлөөгүй байна, гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн 2017 оны 12 дугаар сарын 31-ны хүртэлх хугацааны газар ашиглалтын төлбөрийг нөхөн тооцоход нийт 10,872.8 мянган төгрөг болж, аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.
	2016 оны 5/231-16 дугаар гэрээний 2.5, 2.6	2.5-т “Б” ⁵⁴ тал нь улирал бүрийн санхүүгийн тайлан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн хуулбарыг дараа улирлын эхний сарын 25-ны дотор “А” ⁵⁵ талд хүргүүлнэ... гэж заасан ч санхүүгийн тайлан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн хуулбарыг “А” талд ирүүлсэн эсэх нь тодорхойгүй, 2.6-д ...“Б” тал нь олон улсын нэр хүнд бүхий, ашиг сонирхлын зөрчилгүй, Монгол Улсад аудит хийх эрхтэй аудитын компаниар аудит хийлгэсэн жил бүрийн борлуулалтын орлогын тайланг дараа жилийн эхний улиралд багтаан “А” талд хүргүүлнэ... гэж заасан хэрэгжээгүй.

⁵⁴ “Морьт эксплорейшн” ХХК

⁵⁵ “Эрдэнэт үйлдвэр” ХХК



“Эрдэнэт үйлдвэр” ХХК-д “Ачит Ихт” ХХК-иас ашиглалтын төлбөр тооцон шилжүүлсэн дүнгийн судалгаа

(төгрөгөөр)

огноо	катодын зэс хэмжээ /тн/	борлуулалтын орлого /төгрөг/	ногдуулах хувь	ашиглалтын төлбөр /НӨАТ-гүй/	НӨАТ	Ашиглалтын төлбөр /НӨАТ-тэй/	төлбөрийн дүн	төлбөр төлсөн огноо
2015.07.31	-	68,110,927,359	0.5%	274,500,388.54	27,450,038.85	301,950,427.39	301,950,427.39	2015.07.21
2015.12.31	-	41,548,959,366	0.5%	223,953,642.04	22,395,364.20	246,349,006.24	148,014,144.11	2015.10.01
							98,334,862.13	2016.01.14
2015 оны дүн	-	109,659,886,725		498,454,030.58	49,845,403.05	548,299,433.63	548,299,433.63	
2016.03.31	2,402	21,655,618,661	1%	196,869,260.55	19,686,926.06	216,556,186.61	200,000,000.00	2016.03.29
							16,556,186.61	2016.04.14
2016.07.31	3,602	32,524,122,003	1%	244,668,340.98	24,466,834.10	269,135,175.08	268,000,000.00	2016.07.01
							1,135,175.08	2016.07.26
2016.09.30	3,603	35,859,930,126	1%	377,004,860.19	37,700,486.02	414,705,346.21	414,705,346.21	2016.10.12
2016.12.31	4,203	50,441,324,563	1%	458,557,496.03	45,855,749.60	504,413,245.63		
							504,413,245.63	2017.01.09
2016 оны дүн	13,810	140,480,995,352		1,277,099,957.75	127,709,995.78	1,404,809,953.53	1,404,809,953.53	
2017.03.31							747,595,997.8	2017.04.27
2017.06.30							741,155,176.2	2017.07.20
2017.09.30	-	47,677,520,054	1.5%	650,148,000.7	65,014,800.4	715,162,800.8	715,162,800.8	2017.20.12
2017 оны 3 улирлын дүн	-	47,677,520,054		650,148,000.7	65,014,800.4	715,162,800.8	2,203,913,974.8	
2015-2017 оны нийт	24,341	297,818,402,132		2,425,701,989.07	242,570,199.21	2,668,272,187.97	4,157,023,362.00	

/Эх сурвалж: “Ачит Ихт” ХХК-ийн ирүүлсэн тоон мэдээ, төлбөрийн дүнд суурилж нэгтгэв/



“Эрдмин” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид, дүрмийн санд оруулсан хувь хэмжээ, хөрөнгийн өөрчлөлтийн судалгаа

шийдвэрийн дугаар	хувьцаа эзэмшигчдийн нэр	дүрмийн санд оруулсан хувь хэмжээ	хөрөнгө оруулалтын дүн /ам.доллар/
1994.3.14-ны “Эрдэнэт” концерн, Америкийн “Ар Си Эм” корпораци 2 талын хооронд байгуулсан гэрээ	Эрдэнэт концерн	51	51,000.00
	Ар Си Эм Инк	49	49,000.00
“Эрдмин” ХХК анх үүссэн		100	100,000.00
Эрдмин үйлдвэрийн захирлуудын зөвлөлийн хурлын протокол 2001.04.12	Эрдэнэт УБҮ	25	2,300,000.0
	Эрдэнэт концерн	10	939,731.0
	Ар Си Эм Инк	65	5,899,555.0
“Эрдмин” ХХК нийт хөрөнгө		100	9,139,286.0
Эрдмин үйлдвэрийн 2006 оны 12-р сарын 25-ны хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	Эрдэнэт УБҮ	25.0	2,500,000.0
	Эрдэнэт концерн		-
	Ар Си Эм Инк	58.5	5,850,000.0
	"Мико Холдинг" ХХК	10.0	1,000,000.0
	Иргэн Ж.Дамдинжав	6.5	650,000.0
“Эрдмин” ХХК-ийн нийт хөрөнгө		100.0	10,000,000.0

Газрын төлбөрийн ногдуулалтын судалгаа

(мянган төгрөгөөр)

Газар ашигласан хугацаа	уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж буй талбай	ЗГ-ын 1997 оны 152 дугаар тогтоолоор Улсын зэрэглэлтэй хот “Эрдэнэт” жилийн төлбөр дээд хэмжээ (600.0 мянган төгрөг 1 гектар газарт)
2011.07.15-наас 2011.10.15-ны /3 сар/	28.96	4,344.0
2011.10.15-наас 2012.01.15-нд /3 сар/		4,344.0
2012.01.15-наас 2013.01.15 / 1 жил/		17,376.0
2013.1.015-2014.01.15 /1 жил/		17,376.0
2014.01.16-2014.05.18-ны хооронд /4 сар/		5,792.0
Нийт газрын төлбөрийн дүн	28.96	49,232.0

ТЭМДЭГЛЭЛ